



METHANE GAS
R E S O U R C E

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГТ
ОРШИХ ТАВАНТОЛГОЙ-ХХХIII ГЭРЭЭТ ТАЛБАЙД
НҮҮРСНИЙ ДАВХАРГЫН МЕТАН ХИЙН ХАЙГУУЛЫН
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТӨСЛИЙН 2025 ОНД
ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

АЖ АХУЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6435254

Тайланг хянаж, хүлээн авсан:

Өмнөговь аймгийн Байгаль орчны газрын

Байгаль орчны хяналтын улсын байцаагч

/

/

Тайлан боловсруулсан:

Метан газ ресурс ХХК-ийн

ХАБЭАБО-ны асуудал хариуцсан ажилтан

П.Эрдэнэ

2025 он

1. НҮҮРСНИЙ ДАВХАРГЫН МЕТАН ХИЙН ХАЙГУУЛЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

1.1 Төслийн товч танилцуулга

Төсөл хэрэгжүүлэгч:	“Метан Газ Ресурс” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9011409138
Регистрийн дугаар:	6435254
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамьянгүний гудамж, Даун Таун барилга, 13 давхар 1301 тоот
Төслийн нэр:	Нүүрсний давхаргын метан (НДМ) хийн хайгуулын ажил гүйцэтгэх төсөл
Төслийн зорилго:	Тавантолгойн сав газрын НДМ хийн хайгуулын ажлын үр дүнг нарийвчилж, ордын таамагласан зэрэглэлийн нөөц баялгаас боломжтой зэрэглэлийн нөөцийг тодорхойлох, зэрэглэл нэмэгдүүлэх
Төслийн талбайн байршил:	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цагаан-Овоо баг, Улаан нуурын хөндий
Тусгай зөвшөөрөлтэй талбайн дугаар:	Тавантолгой-XXXIII Бүтээгдэхүүн хуваах гэрээт хайгуулын талбай (Тавантолгойн ордын ашиглалтын MV-016881, MV-016882, MV-016883, MV-011953, MV-011954, MV-011955, MV-011956 7 лицензийн талбайтай давхцалтай)
Талбайн хэмжээ:	629 км ²
Хайгуулын ажлын баг:	Нийт 28 хүнтэй (хайгуулын гэрээт компанийн ажилчид орсон). Хайгуулын ажлыг Австрали улсын уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын чиглэлээр туршлагажсан мэргэжилтэн Марк Питкин удирдаж байна.
Ажиллах хуваарь:	Уртын ээлж 14/14
Хайгуулын кэмгийн зохион байгуулалт:	“Номадс Катеринг энд Интегрэйтед Сервисис” ХХК хангамж, үйлчилгээг хариуцан ажилладаг. Кэмп нийт 30 хүний багтаамжтай.
Өрөмдлөгийн ажлын туслан гүйцэтгэгч:	БНХАУ-ын “Yan'an Drilling Wellking Energy Technology Service” буюу товчилсон нэр – DWK компани
Цахилгаан хангамж:	<ul style="list-style-type: none">- Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээний 380В-ын -ЦДАШ-тай холбогдсон.- 10 кВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан үүсгүүрээр кэмгийн дотуур холбоо, интернэт, шөнийн гэрэлтүүлгийг хангадаг.

- Нөөц эх үүсвэр буюу 130 кВт хүчин чадалтай дизель генератор

Ус хангамж:

Өрөмдлөг: Өрөмдлөгийн компани өрөмдлөгт ашиглах усыг зүүн худгаас зөөвөрлөн ашигласан.
Унд, ахуй: Цогтцэций сумын төвийн худгаас 18 м³ багтаамжтай цистернээр зөөвөрлөн ашигладаг.

Хог хаягдал:

Ахуйн шингэн хаягдал: 35 тн багтаамжтай септик танканд түр хадгалаад тусгай зөвшөөрөлтэй “Өгөөмөр Дэлгэр Ширээт” ХХК-аар бохир соруулах машинаар Энержи Ресурс ХХК-ийн Цогтцэций дэх цэвэрлэх байгууламжид хүргүүлдэг.

Хатуу хог хаягдал: Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж “Тэгш дүүрэн тохижилт” ОНӨААТҮГ-аар 14 хоногт 1 удаа сумын хог хаягдлын нэгдсэн цэг рүү тээвэрлүүлдэг.

Түлшний хангамж:

Hyundai Mighty II маркийн (3 тн багтаамжтай) зориулалтын автомашинаар зөөвөрлөн цэнэглэдэг.

1.2 2025 оны хайгуулын ажлын гүйцэтгэлийн товч танилцуулга

“Тавантолгой-ХХХIII” бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайд гүйцэтгэх хайгуулын ажлыг дараах үндсэн шат дарааллаар гүйцэтгэнэ. Үүнд:

- Бэлтгэл ажил,
- Хээрийн судалгаа,
- Суурин боловсруулалт.

2025 онд хээрийн судалгааны ажлыг доорх дэс дарааллаар гүйцэтгэхээр төлөвлөсөн. Үүнд:


1. Олборлолтын туршилтын ажил,
 - Олборлолтын туршилтын хэвтээ цооногийн өрөмдлөг,
 - Олборлолтын туршилтын цооногийг тоноглох ажил,
 - Олборлолтын туршилтын ажил,
2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажил.

2025 онд олборлолтын туршилтын 1 /нэг/ хэвтээ цооног өрөмдөхөөр төлөвлөсөн бөгөөд толгой компани болох төрийн өмчит Эрдэнэс Монгол ХХК-иас тодорхой чиглэл өгөлгүй хугацаа алдсаны улмаас өрөмдлөгийн ажил 11-р сарын 18-ны өдөр эхэлж, 11-р сарын 30-ны өдөр хэвтээ цооногийн өрөмдлөгийн ажил дууссан. Өрөмдсөн цооногийн мэдээллийг хүснэгтэд үзүүлэв (Хүснэгт 1).

Хүснэгт 1. 2025 онд өрөмдсөн олборлолтын туршилтын хэвтээ цооногийн мэдээлэл:

No	Цооногийн дугаар	Easting	Northing	Өндөр, (mGL)	Нийт өрөмдлөгийн урт, м (MD)	Өрөмдсөн урт, м (MD)	Зорилго
1	RL-001-3b-Hz-03	533488.50	4830740.00	1516	1633.1	64.0	Улааннуурын хэсэгт IIIb давхраасаас олборлолтын туршилт хийх

Тайлбар: 2025 оны 12-р сарын 01-ны байдлаар мэдээллийг оруулав.



Таних тэмдэг


● RL_001_3b_HZ_03	● Цогтэций	—+—+— Төмөр зам	----- Шороон зам
● Өмнө өрөмдсөн хайгуулын цооногууд	— Нүүрс тээврийн зам	— Цанхи хотхон	▨ Ухаа худгийн уурхайн талбай
 Салхин цахилгаан станц	— Цахилгаан станц	▨ Цанхийн уурхайн талбай	

Зураг 1. Тавантолгой-XXXIII гэртээ талбайд 2025 оны хайгуулын цооногуудын байрлалын зураг

Туршилт-ажиглалтын цооногийн хэвтээ өрөмдлөгийн ажил

2025 онд өрөмдөх 1 (нэг) хэвтээ цооногт дараах олборлолтын тоног төхөөрөмжийг суурилуулан хийн олборлолтын туршилтыг хийхээр төлөвлөсөн боловч тодорхой шалтгааны улмаас эхний босоо 64м хүртэл өрөмдөөд үлдсэн өрөмдлөгийг дараа жил хийж гүйцэтгэнэ.

Хэвтээ цооногт суурилуулах үндсэн тоног төхөөрөмжийн жинхэнэ суурилуулах тоног төхөөрөмж нь тухайн үеийн үнэ, олдоц зэрэг хүчин зүйлээс хамааран өөрчлөгдөх магадлалтай. Насосын хэмжээний хувьд туршилтын явцад ажиглагдсан олборлолтын үзүүлэлтээс хамаарна.



Зураг 2. Туршилт – ажиглалтын хэвтээ цооногийн дизайн

1.3 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын гүйцэтгэл

2025 оны БОМТ-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд НДМ хийн хайгуулын ажлыг гүйцэтгэх явцад байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх, хог хаягдлын менежмент, орчны хяналт шинжилгээний ажлуудыг хийсэн.

Хүснэгт 2. 2025 оны БОМТ-ний зардлын нийт хэмжээ

#	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төлөвлөсөн зардал, төг	Гүйцэтгэл, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,250,000.0	865,331.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1,200,000.0	-
3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	1,000,000.0	1,000,000.0
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	150,000.0	200,000.0
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	-	-
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,500,000.0	2,500,000.0
7	Тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	-	-
8	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийг тайлагнах төлөвлөгөө	-	1,000,000.0
Нийт зардал		5,100,000.0	5,565,331.0

2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 3. 2025 оны БОМТ-ний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн нэгдсэн хүснэгт

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжилт ба биелэлт	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Газрын гадарга, хэвлий								
Олборлолтын туршилт хийх хэвтээ цооногуудыг өрөмдөх, ус түр хуримтлуулах санг байгуулахад нийт 6000 м2 талбай эвдэрч, талхлагдана.	Газар шорооны ажлын явцад хуулсан хөрс чулуулгаар овоолго үүсгэн хадгална.	Хэвтээ өрөмдлөгийн талбай	Төг/м ³	-	-	1,265,331.0	2024 онд бэлтгэсэн 6000м2 өрөмдлөгийн талбайд хэвтээ цооногийг өрөмдсөн тул нэмж талбай эвдэрч, талхлагдаагүй.	MNS 5917:2008 (Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага),
Ус хуримтлуулах усан сангийн тусгаарлах материал цоорсон тохиолдолд шингэн нь газрын хэвлийд нэвчиж сөрөг үр дагаваруудыг үүсгэж болзошгүй.	Зумпыг шингэн үл нэвчүүлэх материалаар доторлохдоо цооролт үүссэн эсэхийг сайтар шалгаж дэвсэнэ.	Зумп	Төг/м ²				Өрөмдлөгийн үед ашиглаж байсан зумпыг олборлолт, туршилтын ажилд зориулж шинэчилж байгуулсан. Тус ус хуримтлуулах сан нь 3 тасалгаа бүхий төмөр бетонон доторлогоотой бөгөөд тасалгаа тус бүр нь: 3.4 м өргөн, 2.7 м урт, 3 м-ийн өндөртэй.	
	Өрөмдлөгийн зумпны уснаас дээж авч лабораторид шинжлүүлнэ.	Хэвтээ цооног	ширхэг	-	-		Өрөмдлөгт ашиглаж байгаа уснаас дээж авч, шинжилгээнд хамруулсан. Үр дүнг хавсаргав.	MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага
Хэсгийн дүн						1,256,331.0		
Агаарын чанар								
Хайгуулын ажилд ашиглах тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөнөөр үүссэн тоосжилт тухайн орчны агаар дахь	Хайгуулын ажил эхлэхийн өмнө тээврийн хэрэгслүүд зорчих авто замын маршрутыг гаргана. Маршрут гаргахад	Тээврийн хэрэгслүүд зорчих замын дагууд	Төг/удаа	-	-	200,000.0	1. Замын маршрутыг тогтоож, хурдны хязгаар заасан тэмдэг, тэмдэглэгээг байршуулсан. 2. Тээврийн	Агаарын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, MNS 4585:2016 (Агаарын чанар. Техникийн ерөнхий

тоосонцорын агууламжийг нэмэгдүүлэхэд нөлөөлнө.	одоо байгаа замыг ашиглах бөгөөд шинээр салаа замууд гаргахгүй байхад анхаарна.						хэрэгслүүдийг оношилгоонд хамруулсан. 3. Тээврийн хэрэгслүүдэд өдөр бүрийн үзлэг хийж, шаардлагатай засвар үйлчилгээг хийж ажилласан.	шаардлага)
	Зорчих хурдны хязгаарыг тогтоож тэмдэгжүүлнэ.	Тээврийн хэрэгслүүд зорчих замын дагуу	Төг/ш	-	-	50,000.0		
Хэсгийн дүн						250,000.0		
Дуу шуугиан								
Өрөмдлөгийн ажил гүйцэтгэж буй механизмуудаас үүссэн дуу шуугиан ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, ойролцоо нутаглаж буй малчин иргэдэд тавгүй байдал үүсгэх, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.	Стандартад заасан хэмжээнээс давсан дуу шуугиантай орчинд ажиллаж байгаа ажилчдад сонсгол хамгаалах хэрэгсэл хэрэглүүлж, ажиллах цагийн хувааарийг зохицуулна.	Өрөмдлөгийн талбайд ажиллаж буй ажилчид	Төг/багц	-	-	Үйл ажиллагааны зардал багтсан.	Өрөмдлөгийн талбай дээр ажиллаж буй бүх ажилчид нэг бүрийн хамгаалах хэрэгслийг бүрэн гүйцэт өмсөж ажилласан.	MNS 4585:2016 (Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага)
	Нутгийн иргэдээс санал, гомдол ирсэн тохиолдолд хүлээн авч тухай бүр зохих шийдвэрийг гаргаж ажиллана.	Өрөмдлөгийн талбай түүний орчимд нутаглаж буй малчин өрхүүд	Удаа					Өрөмдлөгийн талбай түүний орчимд нутагладаг айл, малчин өрх байхгүй байсан.
Хэсгийн дүн								
Газрын доорх усны нөөц								
Урьдчилсан тооцоогоор хайгуулын кэмийн унд ахуйн хэрэглээнд 153 м ³ ус хэрэглэнэ. Өрөмдлөгийн ажилд нийт 655 м ³ газрын доорх усыг ашиглахаар байна	Ус ашиглах зөвшөөрөлд заасан хэмжээнд ашиглаж, усны нөөц ашигласны төлбөр төлнө.	Цогтцэций сумын ус хангамжийн худгууд, өөрийн эзэмшлийн 2 худаг	Төг/м ³	-	-	Үйл ажиллагааны зардал багтсан.	- Өрөмдлөгт шаардлагатай усыг өөрийн эзэмшлийн Зүүн худгаас зөвөөрлөн хангасан. - 2025 оны 11-р сарын байдлаар 1171 м ³ ус ашиглаж, тоолуурын заалтаар усны төлбөрийг төлсөн. - Унд ахуйн цэвэр усыг "Өгөөмөр дэлгэр	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Усны тухай хууль, Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай, МУЗГ-ын 2011 оны 10-р сарын 26-ны өдрийн 302-р тогтоол, Усны нөөцийн төлбөрийн хувь хэмжээг тогтоож,

							ширээт" ХХК –с гэрээгээр хангадаг. 150 м3 ус хэрэглэсэн.	хөнгөлөх тухай Засгийн газрын тогтоол (МУЗГ-ын 2013 оны 9-р сарын 21-ний өдрийн 326-р тогтоол), Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, МУЗГ-ын 2013 оны 9-р сарын 21-ний өдрийн 327-р тогтоол
Олборлолтын туршилтын ажлын явцад хэвтээ цооногуудаас ус шавхан зайлуулж болзошгүй	Хэрэв ус гарсан тохиолдолд шавхан зайлуулсан усны хэмжээ (м ³)-ээр ус ашигласны төлбөр төлнө.	Хэвтээ цооног	Төг/м ³	-	-	-	2025 онд шавхан зайлуулалт хийгдээгүй	
Хэсгийн дүн						-		
Хөрсөн бүрхэвч								
Хэвтээ цооног өрөмдөхөд нийт 6000 м ² талбай /зумпуудын талбай багтсан/-н хөрсөн бүрхэвч хуулагдаж, талхлагдана.	Гарсан хөрсийг шимт хөрс болон хөрс ангилан ялгаж овоолго үүсгэн, тусгайлан хадгална.	Хэвтээ өрөмдлөгийн талбай	Төг/м ²	-	-	-	2024 онд бэлтгэсэн өрөмдлөгийн талбайд хэвтээ цооногийг өрөмдсөн тул нэмж талбай эвдэрч, талхлагдаагүй.	MNS 5915:2008 (Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал), MNS 5916:2008 (Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт), MNS 5917:2008 (Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл

<p>хэвтээ 1 цооног өрөмдөх, ус түр хуримтлуулах сангуудыг байгуулах, олборлолтын туршилтын байгууламжуудыг байршуулах талбайн хөрсөн бүрхэвч эвдэрч талхлагдана. Ус түр хуримтлуулах сангийн талбайг нарийвчилсан зураг төслийн ажлын явцад тодорхой болно.</p>	<p>Хэвтээ цооногуудыг өрөмдсөний дараагаар тухайн орчмын талбайг хэлбэржүүлж техникийн нөхөн сэргээлтийг хийнэ.</p>	<p>Хэвтээ өрөмдлөгийн талбай</p>	<p>Төг/м²</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>2024 онд бэлтгэсэн өрөмдлөгийн талбайд хэвтээ цооногийг өрөмдсөн тул нэмж талбай эвдэрч, талхлагдаагүй.</p>	<p>ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага), MNS 6200:2010 (Газрын тосны хайгуул, олборлолт, ашиглалтын үйл ажиллагаанаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага) MNS 5916:2008 (Байгаль орчин, газар шорооны</p>
---	---	----------------------------------	--------------------------	----------	----------	----------	--	--

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжилт ба биелэлт	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөнөөр салаа замууд үүсэж хөрсөн бүрхэвч талхлагдах	Хайгуулын ажил эхлэхийн өмнө тээврийн хэрэгслүүд зорчих авто замын маршрутыг гаргана. Маршрут гаргахад одоо байгаа замыг ашиглах бөгөөд шинээр салаа замууд гаргахгүй байхад анхаарна.	Тээврийн хэрэгслүүд зорчих замын дагууд	Төг/удаа	-	-			ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт)
Тээврийн хэрэгслүүдээс ШТМ гоожиж болзошгүй.	Тээврийн хэрэгслүүдийг ажилд гарахын өмнө үзлэг хийнэ.	Хайгуулын ажилд ашиглаж буй бүх тээврийн хэрэгсэл	Төг/сар	-	-		Өрөмдлөгийн машины доор ШТМ үл нэвчүүлэхийн тулд хайрга дэвсэж зассан.	
	Өрөмдлөгийн машины доор үл нэвчүүлэх материал дэвсэж шороогоор манана.	Өрөмдлөг хийх машин механизмууд	-	-	-	400,000.0		
	ШТМ асгарсан тохиолдолд ашиглах зориулалтын шингээгч материалыг бэлэн байлгана.	Өрөмдлөгийн талбай, хайгуулын кэмп	Төг/багц	-	-			ШТМ асгарсан тохиолдолд ашиглах зориулалтын шингээгч материалыг бэлэн байлгасан.
Өнгөн хөрс салхинд хийсэх, шим тэжээлийн бодисуудын агууламж буурч болзошгүй.	Өрөмдлөгийн ажлын үед өнгөн хөрсийг машин, техникийн хөдөлгөөнд саад болохооргүй, чулуулагтай холилдохгүй газар, салхины чиглэлийн дагуу түр байршуулна.	Шимт хөрсний овоолго	Төг/цооног	-	-		2024 онд бэлтгэсэн өрөмдлөгийн талбайд хэвтээ цооногийг өрөмдсөн тул нэмж талбай эвдэрч, талхлагдаагүй.	
Хэсгийн дүн						400,000		
Ургамлан нөмрөг								

Хэвтээ 1 цооног өрөмдөх, ус түр хуримтлуулах сангуудыг байгуулах, олборлолтын туршилтын байгууламжуудыг байршуулах явцад нийт 6000 м ² талбайн ургамлан нөмрөг хөрсөн бүрхэвчийн хамт хуулагдаж, талхлагдана.	Хэвтээ цооногуудыг өрөмдсөний дараагаар тухайн орчмын талбайг хэлбэржүүлж техникийн нөхөн сэргээлтийг хийнэ.	Өрөмдлөг хийх 1 цооногийн талбай орчим	Төг/м ²	-	-	-	2024 онд бэлтгэсэн өрөмдлөгийн талбайд хэвтээ цооногийг өрөмдсөн тул нэмж талбай эвдэрч, талхлагдаагүй.	Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчин, эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага)
Хэвтээ 1 цооног өрөмдөх, ус түр хуримтлуулах сангуудыг байршуулах явцад нийт 6000 м ² талбайн ургамлан нөмрөг хөрсөн бүрхэвчийн хамт хуулагдаж, талхлагдана.	Ус түр хуримтлуулах сангуудаас хуулсан хөрс чулуулгаар далан байгуулан хэлбэршүүлнэ.	Хэвтээ цооногуудын дэргэд ус түр хуримтлуулах сан байгуулах талбай	-	-	-	-	Өрөмдлөгийн машины доор, автомашины зогсоолын доор ШТМ үл нэвчүүлэх материал дэвсэж, хайргаар давхарласан.	
Хэсгийн дүн								
Амьтны аймаг								
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, гэрэл, дуу шуугианаас нийт нутгаар элбэг тархацтай амьтад /тагтаа, шаазгай/ үргэх, мөн хөхтөн амьтад идээшлэхэд саад учруулж болзошгүй.	Тээврийн хэрэгслүүд замын тогтсон маршрутаар зорчих бөгөөд дуут дохио өгөхгүй байхад анхаарч ажиллана.	Хэвтээ өрөмдлөгийн талбайн орчим	Төг/удаа	.	Өдөр бүр		Тээврийн хэрэгслүүд замын тогтсон маршрутаар зорчиж, дуут дохио өгөхгүй байхад анхаарч ажилласан.	Амьтны тухай хууль, 2012 6.1.3. Амьтны хэвийн өсөлт үржилтийг хадгалах, тархац нутгийг хамгаалах, нүүдлийн замыг чөлөөтэй байлгах
Хэсгийн дүн						-		
Нийгэм, эдийн засаг								
Нутгийн иргэдийн ёс уламжлал, зан заншлыг мэдэхгүй байх зэргээс үүдэн ажилчид болон иргэдийн хооронд үл ойлголцол үүсэж маргаан гарч болзошгүй. Нийт ажилчид нутгийн иргэдтэй хүндэтгэлтэй харьцах, тэдний тавьсан санал, хүсэлтийг хүлээн авч, зохих хариуг албан ёсоор өгч ажиллана.		Хайгуулын кэмп, өрөмдлөгийн ажил хийх талбай	-	-	-		Нийт ажилчид кэмийн дотоод журам, аюулгүй ажиллганы удирдамжийг мөрдөж ажилласан.	
Хэсгийн дүн						-		
Нийт дүн						1,865,331.0		


2.2 Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ

Хүснэгт 4. Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
Удирдлага, зохион байгуулалт			
БОМТ боловсруулах, хэрэгжүүлэх	Тухайн жилийн БОМТ-г боловсруулж, БОАЖЯ-аар хянуулж батлуулна. Батлагдсан БОМТ-г хэрэгжүүлнэ.	Метан Газ Ресурс ХХК, гэрээт компани	2025 оны БОМТ-г БОАЖЯ-аар батлуулсан.
Байгаль орчныг хамгаалах чиглэлээр инженер, хайгуулын талбайн ажилчдыг чадавхжуулах	Ажилчдад олгодог хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ээлжит сургалтын хөтөлбөрт байгаль орчныг хамгаалах чиглэлийн ажлуудыг тайлбарлан таниулна.	Метан Газ Ресурс ХХК- ийн удирдлага, үндсэн болон гэрээт ажилчид	Үндсэн болон гэрээт компанийн ажилчдад Байгаль орчны бодлого, байгаль орчныг хамгаалах журам болон Аюулгүй ажиллагааны хугацаат зааварчилгааны хүрээнд байгаль орчныг хамгаалах, болзошгүй нөлөөллүүдээс сэргийлэх, бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын зааварчилгааг өгч ажилласан. Өрөмдлөгийн аюулгүй ажиллагаанд хяналт тавих, болзошгүй эрсдэлүүдээс сэргийлэхэд ээлжийн ахлагч нар хяналт тавьж ажилласан.

2.3 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

2025 онд 1 хэвтээ цооног өрөмдсөн бөгөөд энэ цооног нь 2024 онд бэлтгэсэн 6000 м.кв талбай дотор өрөмдсөн. Тийм учраас нэмж талбай талхлагдаагүй бөгөөд энэхүү цооногийг ажиглалт, туршилтын ажил дууссаны дараа нөхөн сэргээлт хийгдэх юм.



Зураг 31. Хэвтээ өрөмдлөгийн цооногийн байршлын зураг

2.4 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

“Метан Газ Ресурс” ХХК-ийн НДМ хийн хайгуулын Тавантолгой-XXXIII БХГ талбайн хэмжээнд байгаа түүх, соёлын дурсгалт зүйлүүдийг “Эрдэнэс тавантолгой” ХК хайгуул болон ашиглалтын хугацаанд мэргэжлийн байгууллагаар түүх, соёлын өв, дурсгалт зүйлүүдийг илрүүлэх судалгааг хэсэгчилэн хийлгэж, илрүүлсэн дурсгалыг авран хамгаалах ажлыг гүйцэтгэдэг. Энэхүү ажилд зохих хэмжээгээр хамтран оролцохоор төлөвлөж, тодорхой мөнгөн дүнгээр зардалд тусган оруулсан боловч тайлант онд тодорхой шалтгаануудын улмаас хийгдээгүй.

2025 оны хайгуулын ажлын явцад газрын хэвлийд палеонтологи болон археологийн олдвор илрээгүй.

Цогтцэций сумын хэмжээнд ЗДТГ-тай хамтран соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлж буй байгууллагыг дэмжих зорилгоор 1,000,000 (нэг сая) төгрөг төлөвлөсөн бөгөөд 2026.01.30-нд болсон “Тэмээчдийн баяр 2026”-д дэмжлэг үзүүлсэн.


2.5 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Өрөмдлөг болон кэмгийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг түр хадгалах цэгт ангилан, цуглуулдаг бөгөөд Цогтцэций сумын хог хаягдлын менежмент хийдэг тусгай зөвшөөрөлтэй “Тэгш дүүрэн тохижилт” ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээний дагуу тээвэрлүүлдэг. Хайгуулын кэмгийн ахуйн хэрэглээнээс үүссэн шингэн хаягдлыг 2 дамжлагатай тунгаах худгаар цэвэрлэж, 35 м3 багтаамжтай бохирын септик танкинд цуглуулдаг. Цуглуулсан бохир усыг Цогтцэций сумын тусгай зөвшөөрөлтэй “Өгөөмөр Дэлгэр Ширээт” ХХК-аар Энержи Ресурс ХХК-ийн цэвэрлэх байгууламж руу тээвэрлүүлдэг (Хатуу, шингэн хог хаягдал тээвэрлэх гэрээнүүдийн хуулбарыг тайланд хавсаргав).

Хайгуулын үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлыг ангилан ялгах, түр хадгалах, тээвэрлэх, төвлөрсөн цэгт хүргэх ажлыг байгаль орчинд сөрөг нөлөө багатайгаар менежмент хийхээр төлөвлөсөн. Энэ чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн биелэлтийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 4. 2025 оны хог хаягдлын менежментийн биелэлт

Чиглэл	Хог хаягдлын менежментийн арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Биелэлт
Ахуйн хог хаягдлын менежмент	Цугларсан хатуу хог хаягдлыг хог хаягдлын төвлөрсөн цэгт тээвэрлэн хүргэх	Хог хадгалах цэг дүүрсэн тухай бүрд	“Тэгш дүүрэн тохижилт” ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээний дагуу хатуу хог хаягдлыг Цогтцэций сумын төвлөрсөн хогийн цэгт хүргүүлсэн. “Өгөөмөр Дэлгэр Ширээт” ХХК кэмгийн ахуйн бохир усыг зөөвөрлөх менежментийг хариуцан ажиллаж байна (Гэрээг тайлангийн хавсралтаас үзнэ үү).
	Бохирын танкинд хуримтлагдсан шингэн хаягдлыг сумын төвлөрсөн цэгт нийлүүлэх	Дүүрэхээс өмнө	
	Пластик хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа эрхэлдэг компанид тээвэрлэн хүргэх	Хог хадгалах цэг дүүрсэн тухай бүрд	



Зураг 4. Өрөмдлөгийн талбай дахь хог хаягдлыг түр хадгалах сав

Өрөмдлөг болон кэмпийн үйл ажиллагаанаас гарсан хатуу хог хаягдлыг түр хадгалах цэгт цуглуулж, ангилан ялгадаг бөгөөд Цогтцэций сумын хог хаягдлын менежмент хийх тусгай зөвшөөрөлтэй “Тэгш дүүрэн тохижилт” ОНӨААТҮГ-аар 14 хоногт 1 удаа тээвэрлүүлдэг.



Зураг 5. Хайгуулын кэмп дэх хог хаягдлыг ангилан ялгаж, түр хадгалах цэг

Хайгуулын кэмпийн ахуйн шингэн хаягдлыг 35 м^3 багтаамжтай бохирын септик танканд цуглуулдаг. Цогтцэций сумын тусгай зөвшөөрөлтэй “Өгөөмөр Дэлгэр Ширээт” ХХК-аар 7 хоногт 1 удаа 18 м^3 багтаамжтай бохир соруулах машинаар Энержи Ресурс ХХК-ийн цэвэрлэх байгууламжид хүргэдэг. Нэг удаагийн тээвэрлэлтээр ойролцоогоор $15-18 \text{ м}^3$ бохир ус тээвэрлэдэг.



Зураг 6. Ахуйн бохирын цооногос бохир усыг татан тээвэрлэж буй байдал

Хүснэгт 6. Ахуйн бохир ус зөөвөрлөсөн бүртгэл

#	Огноо	Утга	Хэмжээ, ТН
1	2025.10.07	Бохир ус соруулсан	15
2	2025.10.18	Бохир ус соруулсан	15
3	2025.10.24	Бохир ус соруулсан	18
4	2025.10.27	Бохир ус соруулсан	18
5	2025.10.30	Бохир ус соруулсан	18
6	2025.11.04	Бохир ус соруулсан	18
7	2025.11.08	Бохир ус соруулсан	15
8	2025.11.13	Бохир ус соруулсан	15
9	2025.11.17	Бохир ус соруулсан	15
10	2025.11.25	Бохир ус соруулсан	15
Дүн			162

Эх сурвалж: Номадс Катеринг Интегрэйтэд Сервисис ХХК-ийн бүртгэлийн мэдээллээс авав.

Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, Пласик хог хаягдал, бусад хог хаягдал гэж ангилан ялгаж, цугларсан пластик хог хаягдлыг 10-р сарын 26-ны өдөр “Ханбогд вэйст менежмент центр ХХК” -д тээвэрлэн хүргэж тушаасан.

НХМажет БМ-2

Салбартай сийдэн 2017 оны 347 дугаар журамтай хамрагтай

ОРЛОГТҮЙН БАРИМТ № _____

2024 оны 10 сарын 26 өдөр

Ханбогд вэйст менежмент центр ХХК
(байгууллагын нэр)

Метал хог ресурс ХХК
(бэлтгэн нийлвэрлэхийн нэр)

Далд өгөх баримт № _____

№	Материалын утга тусгай нэр, хэрэг, дугаар	Код	Хэмжээг нээж	Нэг бүрийн үнэ	Хүлээн авсан	
					Тоо	Үнэ
1	Абсолют		кг	300	100	30000
2	Хог		кг	300	52	41600
Дүн						71600

Хүлээн авсан: *[Signature]*

Хүлээгдсэн өссөн: *[Signature]*

Тамдг:

Зураг 2. Хуванцар хог хаягдлыг Ханбогд вэйст менежмент центр ХХК-д тушаасан баримт



Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгадаг бөгөөд ашигласан батарейг шууд хаялгүй тусгайлан бэлдсэн хайрцагт цуглуулж байна.

Зураг 7. Ашигласан батарейг цуглуулдаг хайрцаг

2.6 Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Өрөмдлөгийн ажил гүйцэтгэж байгаа машин, механизмуудын эвдрэл, хүний хариуцлагагүй, болгоомжгүй үйлдлийн улмаас хүний эрүүл мэндэд болон байгаль орчинд хохирол учруулах эрсдэлийг үүсгэж болзошгүй юм.

Түүнчлэн Цогтцэций суманд сүүлийн жилүүдэд газар хөдлөлт хэд хэд бүртгэгдсэн нь зайлшгүй анхаарах зүйлсийн нэг болж байна. Иймд болзошгүй газар аюултай тохиолдлын үед ажилчид амь насаа хамгаалах мэдлэгтэй байх нь чухал. Мөн цаг уурын хүчин зүйлсийн үйлчлэлээр шороон шуурга болох давтамж нэмэгдэх хандлагатай байна. Иймд хүчтэй салхи шуургатай үед хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг төлөвлөх нь ажилчдын эрүүл мэндийг эрсдэлд оруулахаас сэргийлэх арга хэмжээнүүдийн нэг хэсэг болно.

Иймд 2025 онд гүйцэтгэх хайгуулын ажлын явцад гарч болзошгүй осол, эрсдэлийг үндсэн 2 хэсэгт ангилан хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлтийг /Хүснэгт 7/- д үзүүлэв.

Хүснэгт 5. Осол эрсдлийн менежментийн биелэлт

Болзошгүй осол, эрсдэл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлсэн хугацаа	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
Машин механизмуудын эвдрэл, ажилчдын хариуцлагагүй, болгоомжгүй үйлдлээс хүний эрүүл мэнд хохирох, байгаль орчныг бохирдуулж болзошгүй.	Хайгуулын ажил эхлэхийн өмнө нийт ажилчид /гэрээт компанийн ажилчид хамаарна/ хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан байна. Хариуцаж буй ээлжийн инженер хэвийн хяналтыг хариуцан ажиллана.	Өрөмдлөгийн талбай, олборлолтын туршилт хийх цооногууд, хайгуулын кэмп	Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны туршид	Хайгуулын талбайд ажиллау буй нийт ажилчдад ХАБЭА-н тухай хууль болон MNS4969:2000 стандартын дагуу Нийт ажилчдын сургалтыг өгч гарын үсэг зуруулан ажилласан.
Байгалийн давагдашгүй хүчин зүйлсээс үүдэлтэй аюулт үзэгдэл (шороон шуурга, газар хөдлөлт г.м)-үүдийн үед ажилчдын эрүүл мэнд, амь нас хохирч болзошгүй	Хайгуулын кэмп дээр шаардлагатай тэмдэг тэмдэглэгээг нэмэлтээр байршуулна.	Хайгуулын кэмп	150,000	2025 оны хайгуулын ажил эхлэх үед	Хурдны хязгаарын тэмдэг, автозамын заах тэмдэгүүд, автомашины аюулгүйн дарцагийг шинээр авч сольсон.
	Нийт ажилчдад өгөх хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалтын хүрээнд байгалийн давагдашгүй хүчин зүйлс тохиолдсон үед амь насаа аврах мэдээллүүдийг өгнө.	Үндсэн болон гэрээт компанийн ажилчид	Үйл ажиллагааны зардал	2025 оны турш шаардлагатай үед	Ажил эхлэхийн өмнө нийт ажилчдад Онцгой байдлын үед ажиллах сургалт зааварчилгаа өгч, гарын үсэг зуруулсан.
Нийт зардал			150,000		

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

2025 оны БОМТ-ний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан байгаль орчны бүрдэл хэсэг тус бүрийн хяналт шинжилгээ, хэмжилт, дээжлэлт авах ажлыг холбогдох стандарт, аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн бөгөөд үр дүнг хүснэгт 8-д дэлгэрүүлэн үзүүлэв.

Хүснэгт 8. 2025 оны агаарын чанарын хяналт-шинжилгээний төлөвлөгөө ба биелэлт

Төлөвлөгөө				Биелэлт		
Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Байршил	Хугацаа ба давтамж	ХШ-ний ажлын хэмжээ	Хяналт шинжилгээ хийсэн үзүүлэлт	Байршил	ХШ-ний ажлын хэмжээ
Агаар бохирдуулагч SO ₂ , NO ₂ , PM ₁₀ , PM _{2.5}	Өрөмдлөгийн талбайд-1 цэг Хайгуулын кэмп-1 цэг У.Одсүрэнгийн өвөлжөө, хаваржааны орчимд 1 цэг, У.Одсүрэнгийн зуслан, намаржааны орчимд-1 цэг, нэр тодорхойгүй өвөлжөөний орчимд-1 цэг	Хайгуулын ажлын үед жилд 1 удаа мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.	5 цэгт	<u>Түгээмэл бохирдуулагчид:</u> Азотын давхар исэл (NO ₂) Хүхрийн давхар исэл (SO ₂) Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) <u>Тоосонцор:</u> Жижиг ширхэглэгт тоосонцор (PM _{2.5}) Том ширхэглэгт тоосонцор (PM ₁₀) Нийт тоосонцор (TSP)	-Хайгуулын кэмп, -Хэвтээ өрөмдлөгийн талбайд -С.Чулуун, О.Бямбаагийн өвөлжөөний зүүн урд - Б.Мөнхболдын өвөлжөөний зүүн талд -Хайгуулын талбайн урд хэсэгт буюу хуучнаар Дамчаагийн Наранцэцэгийн өвөлжөөний зүүн талд -Кэмп-Хэвтээ өрөмдлөгийн талбай хоорондын зам дагууд буюу нийт 6 цэгт 1 удаа хэмжилт хийсэн.	6 цэг*6 үзүүлэлт*1 удаа

Хайгуулын талбайгаас хойд зүгт нутаглаж байсан У.Одсүрэнгийнх Эрдэнэс Тавантолгой ХК-ийн нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын хөтөлбөрт хамрагдан нүүсэн тул төлөвлөсөн 2 цэгийн байршлыг өөрчилж, хайгуулын талбайд нутаглаж буй дараах 3 малчны өвөлжөөнд хэмжилтийг хийсэн.

Хайгуулын талбайд 2025 оны байдлаар малчин өрхүүд болох С.Чулуун, О.Бямбаа болон Б.Мөнхболд нар нутаглаж байна. Гэвч эдгээр малчдын өвөлжөөний газар нь ЭТТ ХК-ийн ашиглалтын лицензийн талбайд байрлах тул цаашид ЭТТ ХК-ийн нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын хөтөлбөрт хамрагдахаар болсон байна. Метан газ ресурс ХХК-ийн хайгуулын талбай нь Эрдэнэс Тавантолгой ХК-ийн ашиглалтын 7 лицензийн талбайтай давхцаж байрладаг.

2025 оны байдлаар эдгээр 3 малчин өрх хайгуулын талбайд байрлах өвөлжөөндөө нутаглаж байсан тул агаарын чанарын хэмжилтийг хийсэн.

Хүснэгт 9. Агаарын чанарын хяналт-шинжилгээ хийсэн цэгүүд, тэдгээрийн байршил

Хяналт-шинжилгээ хийсэн цэгүүд	Хяналт-шинжилгээний байршил	Байршлын солбицол	
		ХӨ	ЗУ
AQ01	Метан Газ Ресурс ХХК-ийн хайгуулын кэмп	43° 38' 32.400	105° 23' 6.600
AQ02	Хайгуулын хэвтээ өрөмдлөгийн талбайд	43° 37' 42.967	105° 24' 54.09
AQ03	С.Чулуун, О.Бямбаагийн өвөлжөөний зүүн урд	43° 38' 28.277	105° 19' 26.36
AQ04	Б.Мөнхболдын өвөлжөөний зүүн талд	43° 36' 49.709	105° 20' 33.03
AQ05	Судалгааны талбайн урд хэсэгт буюу хуучнаар Дамчаагийн Наранцэцэгийн өвөлжөөний зүүн талд	43° 36' 15.700	105° 22' 52.80
AQ06	Кэмп-Хайгуулын хэвтээ өрөмдлөгийн талбай хоорондын зам дагууд	43° 37' 55.178	105° 23' 9.049

Хайгуулын талбайн агаарын чанарын хэмжилтийг 6 үзүүлэлтээр, 6 цэгт Aeroqual Ranger маркийн автомат багажийг ашиглан хийсэн.


Хүснэгт 10. Агаарын чанарын хяналт-шинжилгээ хийсэн үзүүлэлтүүд ба хугацаа

#	Хэмжсэн үзүүлэлтүүд	Хэмжилтийн хугацаа
1	Жижиг ширхэглэгт тоосонцор (PM2.5)	1 цаг
2	Том ширхэглэгт тоосонцор (PM10)	1 цаг
3	Нийт тоосонцор (TSP)	20 минут
4	Азотын давхар исэл (NO ₂)	20 минут
5	Хүхрийн давхар исэл (SO ₂)	20 минут
6	Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)	20 минут

Агаарын чанарын хяналт-шинжилгээний цэгүүдэд хэмжилт хийж байх үеийн гэрэл зургуудыг доорх хэсэгт үзүүлээ.



AQ01 Хайгуулын кэмп



AQ02 Хэвтээ өрөмдлөгийн талбайд



AQ03 С.Чулуун, О.Бямба нарын өвөлжөөний зүүн урд



AQ04 Б.Мөнхболдын өвөлжөөний зүүн талд




AQ05 Судалгааны талбайн урд хэсэгт



AQ06 Кэмп-Хэвтээ өрөмдлөгийн талбай хоорондын зам дагууд

Зураг 8. Агаарын чанарын хяналт-шинжилгээний цэгүүд




Зураг 9. Агаарын чанарын хяналт-шинжилгээ хийсэн цэгүүд

Агаарын чанарын хяналт-шинжилгээний үр дүн

НДМХ-ийн хайгуулын талбайн 6 байршилд хийсэн агаарын чанарын хяналт-шинжилгээний үр дүнг Монгол улсын Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2025 стандартын Хүлцэх агууламж болон ОУСК, Дэлхийн банкны Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа (БОЭМАА)-ны ерөнхий удирдамж (2007)-ийн утгатай харьцуулан энэ хэсэгт үзүүллээ.

Жижиг ширхэглэгт тоосонцор (PM2.5)


Жижиг ширхэглэгт тоосонцор (PM2.5)-ийн агууламж бүх цэгт MNS 4585:2025 стандартын хүлцэх хэмжээ (37.5 мкг/м³)-нээс даваагүй. Харин AQ05 цэгт ОУСК (2007)-ийн удирдамжийн утга (25.0 мкг/м³)-аас 5.9 мкг/м³-ээр их, бусад цэгүүдэд бага байна (Дүрслэл 2.1).



Дүрслэл 3.1 Жижиг ширхэглэгт тоосонцор (PM2.5)-ын хэмжилтийн үр дүнг стандарттай харьцуулсан байдал

Том ширхэглэгт тоосонцор (PM10)


Том ширхэглэгт тоосонцор (PM10)-ийн агууламж зөвхөн AQ05 цэгт MNS 4585:2025 стандартын хүлцэх хэмжээ (100 мкг/м³)-нээс 87.5 мкг/м³-ээр их, ОУСК (2007)-ийн удирдамжид заасан утга (50 мкг/м³)-аас 3.8 дахин их байна. Харин бусад цэгүүдэд (AQ01-AQ4, AQ6) үндэсний стандарт болон ОУСК (2007)-ийн удирдамжийн утгаас даваагүй байна.



Дүрслэл 3.2 Том ширхэглэгт тоосонцор (PM10)-ын хэмжилтийн үр дүнг стандарттай харьцуулсан байдал

Нийт тоосонцор (TSP)


Нийт тоосонцор (TSP)-ийн агууламж бүх цэгт MNS 4585:2025 стандартын хүлцэх хэмжээ (500 мкг/м³)-нээс даваагүй. Харин AQ05 цэгийн дундаж утга бусад цэгүүдтэй харьцуулахад 231-255 мкг/м³-ээр их байна. ОУСК (2007)-ийн удирдамжид нийт тоосонцорын зөвшөөрөгдөх утга тогтоогдоогүй байдаг.



Дүрслэл 3.3 Нийт тоосонцор (TSP)-ын хэмжилтийн үр дүнг стандарттай харьцуулсан байдал

Азотын давхар исэл (NO₂)


Азотын давхар исэл (NO₂)-ийн агууламж бүх цэгт MNS 4585:2025 стандартын хүлцэх хэмжээ (200 мкг/м³) болон ОУСК (2007)-ийн зөвшөөрөгдөх утга (200 мкг/м³)-ын аль алианаас нь хэтрээгүй буюу 79.8-102.7 мкг/м³-ийн хооронд байна.



Дүрслэл 3.4 Азотын давхар исэл (NO₂)-ийн хэмжилтийн үр дүнг стандарттай харьцуулсан байдал

Хүхрийн давхар исэл (SO₂)


Хүхрийн давхар исэл (SO₂)-ийн агууламж AQ03, AQ04, AQ05, AQ06 цэгүүдэд MNS 4585:2025 стандартын хүлцэх хэмжээ (450 мкг/м³)-нээс 100-242 мкг/м³-ээр их, ОУСК (2007)-ийн зөвшөөрөгдөх утга (500 мкг/м³)-аас 50-193 мкг/м³-ээр их байна. Харин AQ01 болон AQ02 цэгүүдэд үндэсний стандарт болон ОУСК (2007)-ийн удирдамжийн утгаас хэтрээгүй буюу 175.3-286.7 мкг/м³-ийн хооронд байна.



Дүрслэл 3.5 Хүхрийн давхар исэл (SO₂)-ийн хэмжилтийн үр дүнг стандарттай харьцуулсан байдал

Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)

Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)-ийн агууламж бүх цэгт MNS 4585:2025 стандартын хүлцэх хэмжээ (60000 мкг/м³)-нээс даваагүй. Харин AQ01 цэгийн дундаж утга бусад цэгүүдтэй харьцуулахад өндөр байна. ОУСК (2007)-ийн удирдамжид нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)-ийн зөвшөөрөгдөх утга тогтоогдоогүй байдаг.



Дүрслэл 3.6 Нүүрстөрөгчийн дутуу исэл(CO)-ийн хэмжилтийн үр дүнг стандарттай харьцуулсан байдал

Физик бохирдол буюу дуу шуугианы ОХШХ-ийн биелэлт


2025 оны батлагдсан БОМТ-нд нийт 5 цэгт, жилд 1 удаа дуу шуугианы хэмжилт хийхээр төлөвлөсөн ба тухайн жилийн ОХШХ-ийн биелэлтийн ажлын хүрээнд 6 цэгт, дуу шуугианы хэмжилтийг хийсэн (**Хүснэгт 11**).

Хүснэгт 11. 2025 оны дуу шуугианы хяналт-шинжилгээний төлөвлөгөө ба биелэлт

Төлөвлөгөө				Биелэлт		
Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Байршил	Хугацаа ба давтамж	ХШ-ний ажлын хэмжээ	Хяналт шинжилгээ хийсэн үзүүлэлт	Байршил	ХШ-ний ажлын хэмжээ
Дуу шуугианы түвшин, дБА	Өрөмдлөгийн талбайд-1 цэг Хайгуулын кэмп-1 цэг У.Одсүрэнгийн өвөлжөө, хаваржааны орчимд 1 цэг, У.Одсүрэнгийн зуслан, намаржааны орчимд-1 цэг, нэр тодорхойгүй өвөлжөөний орчимд-1 цэг	Хайгуулын ажлын үед жилд 1 удаа мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.	5 цэгт	Дуу шуугианы түвшин	-Хайгуулын кэмп, -Хэвтээ өрөмдлөгийн талбайд -С.Чулуун, О.Бямбаагийн өвөлжөөний зүүн урд - Б.Мөнхболдын өвөлжөөний зүүн талд -Хайгуулын талбайн урд хэсэгт буюу хуучнаар Дамчаагийн Наранцэцэгийн өвөлжөөний зүүн талд -Кэмп-Хэвтээ өрөмдлөгийн талбай хоорондын зам дагууд буюу нийт 6 цэгт 1 удаа хэмжилт хийсэн.	6 цэгт*1 удаа

Хүснэгт 12. Дуу шуугианы хяналт-шинжилгээ хийсэн цэгүүд, тэдгээрийн байршил

Хэмжилт хийсэн цэгийн дугаар	Байршил	Байршлын солбицол	
		ХӨ	ЗУ
N01	Метан Газ Ресурс ХХК-ийн хайгуулын кэмп	43° 38' 32.40"	105° 23' 6.60"
N02	Хэвтээ өрөмдлөгийн талбайд	43° 37' 42.967"	105° 24' 54.09"
N03	С.Чулуун, О.Бямбаагийн өвөлжөөний зүүн урд	43° 38' 28.277"	105° 19' 26.36"
N04	Б.Мөнхболдын өвөлжөөний зүүн талд	43° 36' 49.709"	105° 20' 33.03"
N05	Судалгааны талбайн урд хэсэгт буюу хуучнаар Дамчаагийн Наранцэцэгийн өвөлжөөний зүүн талд	43° 36' 15.700"	105° 22' 52.80"
N06	Кэмп-Хэвтээ өрөмдлөгийн талбай хоорондын зам дагууд	43° 37' 55.178"	105° 23' 9.049"



Зураг 12. Дуу шуугианы хяналт-шинжилгээ хийсэн цэгүүд

Дуу шуугианы түвшнийг дээрх байршлуудад MASTECH MS6300 маркийн багажийг ашиглан газрын гадаргаас дээш 1.5 метр өндөрт, 20 минутаар хэмжсэн (Гэрэл зураг 13).

Дуу шуугианы хэмжилтийн үр дүнг Монгол улсын Агаарын чанарын стандарт (MNS4585:2025)-ын өдрийн цаг (07:00-22:00)-ийн Зөвшөөрөгдөх дээд хэмжээ (60 дБА) болон ОУСК, Дэлхийн банкны Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа (БОЭМАА)-ны ерөнхий удирдамж (2007)-ийн Дуу шуугианы өдрийн цаг (07:00-22:00)-ийн түвшин (55 дБА)-тэй тус тус харьцуулсан. Дуу шуугианы хэмжилт хийж байх хугацаанд хэмжилтэд нөлөөлөх хүчин зүйлүүд (салхи, нохой хуцах, тээврийн хэрэгсэл, генератор, өрмийн машин)-ийг тэмдэглэж, бүртгэл хөтөлсөн.



N01 цэг (Хайгуулын кэмп)-т хэмжилт хийсэн байдал




N02 цэг (Хэвтээ цооног өрөмдсөн талбай)-т хэмжилт хийсэн байдал



N03 цэг (С.Чулуун, О.Бямбаагийн өвөлжөөний зүүн урд)-т хэмжилт хийсэн байдал



N04 цэг (Б.Мөнхболдын өвөлжөөний зүүн талд)-т хэмжилт хийсэн байдал



N05 цэг (Дамчаагийн Наранцэцэгийн өвөлжөөний зүүн талд)-т хэмжилт хийсэн байдал

N06 цэг (Кэмп-Хэвтээ өрөмдлөгийн талбай хоорондын зам)-т хэмжилт хийсэн байдал

Гэрэл зураг 13. Дуу шуугианы хяналт-шинжилгээ хийсэн цэгүүд

Гадаад орчны дуу шуугианы түвшин Монгол улсад MNS 4585:2025 стандартын ЗДХ өдрийн цагт 60 дБА (16 цагийн дундаж), шөнийн цагаар 45 дБА (8 цагийн дундаж), олон улсад ОУСК, Дэлхийн банк (2007)-ны хамтарсан удирдамжид өдрийн цагаар 55 дБА, шөнийн цагаар 45 дБА–аас хэтрүүлэхгүй байхыг заасан байдаг. Орчны дуу шуугианы түвшний стандартын ЗДХ болон удирдамжийн зөвлөх утгыг дараах хүснэгтэд үзүүлэв.


Хүснэгт 13. Дуу шуугианы үндэсний стандарт ба олон улсын удирдамж

Холбогдох стандарт болон удирдамж	Хэмжилтийн дундаж хугацаа	Стандартын ЗДХ болон удирдамжийн зөвлөх утга
MNS 4585:2025. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага	Өдөр (0700 - 2200)	60
	Шөнө (2200 - 0700)	45
ОУСК, Дэлхийн банкны БОЭМАА-ны ерөнхий удирдамж, 2007	Өдөр (0700 - 2200)	55
	Шөнө (2200 - 0700)	45

Дуу шуугианы хяналт-шинжилгээний үр дүн

Хайгуулын талбайн 6 байршилд дундаж түвшинг өдрийн цагт хэмжсэн ба хэмжилтийн дундаж утгуудыг MNS 4585:2025 стандартын өдрийн цагийн (07:00–22:00) Зөвшөөрөгдөх дээд хэмжээ (ЗДХ) болох 60 дБА болон ОУСК, Дэлхийн банкны БОЭМАА-ны ерөнхий удирдамж (2007)-ийн Дуу шуугианы өдрийн цаг (07:00-22:00)-ийн түвшин (55 дБА)-тэй харьцуулан **Дүрслэл 2.1-2.2**-т үзүүлэв.


Хэмжилт хийсэн байршлуудаас N02 цэгт (хэвтээ цооног өрөмдсөн талбай) өрмийн машин болон генератор ажиллаж байх үед хэмжсэн дуу шуугианы дундаж түвшин MNS 4585:2015 стандартын ЗДХ-нээс 1.7 дБА-аар их байна. Харин N02 цэгт (өрмийн машин ажиллаагүй үед) болон бусад хэмжилтийн цэгүүдийн дуу шуугианы дундаж түвшин MNS 4585:2015 стандартын ЗДХ-нээс хэтрээгүй байна.



Дүрслэл 3.7 Дуу шуугианы хэмжилтийн үр дүнг MNS 4585:2025 стандарттай харьцуулсан байдал

Хэмжилтийн үр дүнгээс үзэхэд N02 цэгт (хэвтээ цооног өрөмдсөн талбай) өрмийн машин болон генератор ажиллаж байх үед хэмжсэн дуу шуугианы дундаж түвшин ОУСК, Дэлхийн банкны хамтарсан (2007) удирамжид заасан утгаас 6.7 дБА-аар их байна. Бусад цэгүүдийн дуу шуугианы дундаж түвшин тус удирдамжид заасан утгаас хэтрээгүй байна.

Мөн N02 болон N06 цэгүүдэд дуу шуугианы түвшин өрмийн машин, генератор, мөн ЭТТ-ийн уурхайн хайгуулын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний нөлөөгөөр бусад цэгүүдтэй харьцуулахад өндөр байна.



Дүрслэл 3.8 Дуу шуугианы хэмжилтийн үр дүнг ОУСК, Дэлхийн банкны хамтарсан удирдамж (2007)-ийн утгатай харьцуулсан байдал

Хайгуулын талбайн дуу шуугианы хамгийн их түвшин өрмийн машин болон генератор зэрэг ажиллаж байх үед үүссэн ба 85 дБА-д хүрсэн байна.

Хүснэгт 14. Хяналт-шинжилгээний цэгүүдийн дуу шуугианы хамгийн их, бага болон дундаж утгууд


Цэгийн дугаар	Хэмжилтийн утга, дБА			Салхины дундаж хурд м/с	Дуу шуугианы эх үүсвэр
	Хамгийн их	Хамгийн бага	Дундаж		
N01	54	33.7	36.6	1.3	ЭТТ-н хөрс тээврийн машинууд
N02	73.4	47.5	54.5	3.8	Генератор ажиллаж байв.
	85	61.4	61.7	2.1	Генератор болон өрмийн машин зэрэг ажиллаж байв.
N03	55.5	18.7	24.6	1.9	Нохой хуцах чимээ болон салхи
N04	56.1	27	31.7	3.3	Нохой хуцах чимээ болон салхи
N05	56.7	31.7	44.8	3.3	Салхи болон суудлын 3 машин
N06	61.3	45.9	47.8	5.9	Салхи болон ЭТТ-н хайгуулын машинууд

Газрын доорх усны ОХШХ-ийн биелэлт

2025 оны БОМТ-нд газрын доорх усны хяналт-шинжилгээний дээжлэлтийг хайгуулын кэмгийн унд-ахуйд ашиглаж буй ус, МГР ХХК-ийн өөрийн хайгуулын өрөмдлөгт ашиглах зориулалтаар гаргасан урд болон зүүн худгаас 1 удаа хийхээр тусгасан. 2025 онд 1 цооногт өрөмдлөг хийсэн ба урд худгийг тухайн онд ашиглаагүй тул дээж аваагүй. Тус хяналт-шинжилгээгээр кемпийн унд-ахуйд зөөврөөр ашиглаж буй ус, өрөмдлөгийн цооногоос шавхаж байгаа ус, зүүн худаг, хайгуулын талбайн баруун хэсэгт зэрэгцэн орших Нарангийн худаг болон Нарангийн булгаас дээж авч, шинжлүүлсэн.

Хүснэгт 15. Газрын доорх усны хяналт-шинжилгээний төлөвлөгөө ба биелэлт

Төлөвлөгөө				Биелэлт		
Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Байршил	Хугацаа ба давтамж	ХШ-ний ажлын хэмжээ	Хяналт шинжилгээ хийсэн үзүүлэлт	Байршил	ХШ-ний ажлын хэмжээ
Усны химийн болон хүнд металлын шинжилгээ	Унданд ашиглаж буй ус болон өрөмдлөгт ашиглаж байгаа урд болон зүүн худаг	Хайгуулын кэмгийн унданд ашиглаж буй уснаас 2 удаа мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ. Урд болон зүүн худгаас 1 удаа	5 цэгт	Усны химийн ерөнхий үзүүлэлтүүд болон хүнд металлын шинжилгээ	-Хайгуулын кемпийн унд, ахуйн ус, -Зүүн худаг, -Нарангийн худаг, Өрөмдлөгийн цооногоос шавхаж байгаа ус, -Нарангийн булгаас 1 удаа дээж авч шинжлүүлсэн	5 цэгт*10 дээж*1 удаа



Зураг 14. Газрын доорх усны хяналт-шинжилгээ хийсэн цэгүүд


Газрын доорх усны дээжлэлт, шинжилгээ

Усны дээж авахдаа MNS ISO 5667-11:2000 (Гүний уснаас дээж авах зөвлөмж) стандартыг баримтлан ажилласан. Дээжлэлтийг хийхдээ эхлээд тусгай зориулалтын ариутгасан полиэтилен дээжийн саваа 3 удаа тухайн дээжлэлт хийх гэж байгаа усаар зайлна. Үүний дараа дээжийн саваа дээжээр бүрэн дүүргэж дээр нь агаар байх зайгүйгээр таглана. Ингэснээр тээвэрлэлтийн үед сэгсрэгдэх, хийнүүдийн хоорондох харилцан үйлчлэлийг хязгаарлана. Тээвэрлэлтийн үед дээжүүдийг харанхуй, сэрүүн нөхцөлд хадгалсан.

Усны сорьцуудад ерөнхий химийн шинжилгээг Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн усны шинжилгээний лаборатори, Усны газрын Усны хяналтын төв лабораторид; хүнд металлын шинжилгээг Эс Жи Эс ИММЭ Монголиа лаборатори, Усны газрын Усны хяналтын төв лабораторид тус тус шинжлүүлсэн. Лабораторийн шинжилгээний үр дүнг MNS 0900:2018 (Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ), MNS 4943:2015 (Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Бохир ус. Ерөнхий шаардлага) стандарттай харьцуулсан.



Гэрэл зураг 15. Нарангийн худаг ба усны дээжлэлт




Гэрэл зураг 16. Нарангийн булаг ба усны дээжлэлт



Гэрэл зураг 17. Кемпийн усны нөөцийн сав ба дээжлэлт



Гэрэл зураг 18. МГР ХХК-ийн Зүүн худаг ба усны дээжлэлт



Гэрэл зураг 19. Хэвтээ өрөмдлөгийн цооног ба усны дээжлэлт

Газрын доор усны хяналт-шинжилгээний үр дүн

Метан газ ресурс ХХК нь өрөмдлөгийн ажилд шаардлагатай усыг өөрийн эзэмшлийн Зүүн худгаас хангаж байна. Энэ худагт тоолуур тавьж, тоногосон. Кемпийн унд, ахуйн хэрэглээний усыг Цогтцэций сумын төвийн худгаас зөөврөөр хангадаг бөгөөд зориулалтын ган саванд хадгалдаг.

Зүүн худаг, Нарангийн худаг, булаг, кемпийн унд, ахуйн усны сорьцуудад хийсэн ерөнхий шинжилгээний үр дүнг MNS 0900:2018 (Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ) стандарттай харьцуулан **Хүснэгт 16**-д үзүүлэв.

Усны ерөнхий шинжилгээний үр дүнгээс үзэхэд:

- Кемпийн унд, ахуйн ус нь химийн бүрэлдэхүүнээрээ хлор-сульфатын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд давсархаг, маш хатуу ус байна. Шинжилсэн үзүүлэлтүүдээс нийт эрдэсжилт, ерөнхий хатуулаг, кальци, магни, натри, хлор, сульфатын агууламж нь MNS 0900:2018 стандартад заасан хэмжээнээс их байна.
- Нарангийн худаг болон Нарангийн булгийн ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натри-кальцийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү, зөөлөвтөр ус байна. Шинжилсэн үзүүлэлтүүд нь MNS 0900:2018 стандартын шаардлага хангаж байна.

- Зүүн худгийн ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, 2-р төрлийн, чанарын хувьд давстай, маш хатуу ус байна. Шинжилсэн химийн үзүүлэлтүүдээс нийт эрдэсжилт, ерөнхий хатуулаг, магни, натри, төмөр, хлор, сульфатын агууламж нь MNS 0900:2018 стандартад заасан хэмжээнээс их байна.

Хүснэгт 16. Усны ерөнхий шинжилгээний үр дүн (2025.11)

#	Үзүүлэлт, нэгж	Кемпийн худаг	Нарангийн худаг	Зүүн худаг	Нарангийн булаг	MNS 0900:2018
1	Cl ⁻ , мг/л	489.5	63.5	352.2	65.0	350
2	SO ₄ ²⁻ , мг/л	535.0	85.0	889.0	120.0	500
3	NO ₂ ⁻ , мг/л	0.0	0.0	0.0	0.05	1
4	NO ₃ ⁻ , мг/л	35.0	14.0	1.0	24.0	50
5	CO ₃ ²⁻ , мг/л	12.0	0.0	18.0	0.0	-
6	HCO ₃ ⁻ , мг/л	170.8	244.0	2169.0	213.5	-
7	Нийт анион	1242.3	406.5	3456.2	422.5	-
8	Na ⁺ + K ⁺	342.7	74.7	1273.4	77.5	-
9	Ca ²⁺ , мг/л	180.0	52.7	26.9	64.3	100
10	Mg ²⁺ , мг/л	58.6	23.2	100.9	19.9	30
11	NH ₄ ⁺ , мг/л	0.0	0.0	0.0	0.0	1.5
12	Fe ²⁺ , мг/л	0.0	0.0	0.0	0.0	-
13	Fe ³⁺ , мг/л	0.0	0.0	1.0	0.0	-
14	Нийт катион	581.3	150.6	1402.1	161.7	-
15	Нийт ион	1823.6	557.1	4858.3	584.3	-
16	Хатуулаг, мг-экв/л	13.8	4.54	9.64	4.85	7
17	pH	7.71	7.32	8.03	7.28	6.5-8.5
18	ЦДЧ, мксм/см	2570	780	5190	789	-
19	ПИЧ, мг/л	1.44	1.44	1.44	4.80	-
20	TDS, ppm	1542	429	3633	434	-

Эх сурвалж: Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн усны шинжилгээний лабораторийн үр дүн, 2025.11.27

Усны хүнд металлын шинжилгээний үр дүнг MNS 0900:2018 стандарттай харьцуулан **Хүснэгт 17**-д үзүүлэв. Тус шинжилгээний үр дүнгээс үзэхэд кемпийн усны кальцийн хэмжээ; Зүүн худаг, кемпийн усны магни, натри, стронцийн хэмжээ MNS 0900:2018 стандартад заасан хэмжээнээс их байна. Нарангийн худаг, булгийн усны хүнд металлын агууламж MNS 0900:2018 стандарт хэмжээнээс хэтрээгүй байна.

Хүснэгт 17. Усны хүнд металлын шинжилгээний үр дүн

#	Үзүүлэлт, нэгж	Дээжний нэр				MNS 0900:2018
		Зүүн худаг	Кемпийн ус	Нарангийн худаг	Нарангийн булаг	
1	Al, мкг/л	378	22	95	152	-
2	Ba, мкг/л	18	<10	<10	12	700
3	Ca, мг/л	26.9	180	58.3	66.8	100
4	Cr, мкг/л	<10	<10	<10	<10	50
5	Cu, мкг/л	6	10	<5	<5	2000
6	Fe, мкг/л	9917	<50	<50	<50	-
7	K, мг/л	3.9	1.7	1.1	1.1	-
8	Mg, мг/л	93.1	50.7	16	16.8	30
9	Mn, мкг/л	48	<5	9	25	100

#	Үзүүлэлт, нэгж	Дээжний нэр				MNS 0900:2018
		Зүүн худаг	Кемпийн ус	Нарангийн худаг	Нарангийн булаг	
10	Na, мг/л	1280	337	85.1	79.6	200
11	P, мкг/л	<50	<50	<50	<50	-
12	Sr, мкг/л	3081	4009	1049	1012	2000
13	Ti, мкг/л	<10	<10	<10	<10	-
14	V, мкг/л	<10	<10	<10	<10	-
15	Zn, мкг/л	<5	<5	<5	<5	-
16	Be, мкг/л	<0.1	<0.1	<0.1	<0.1	0.2
17	Sc, мкг/л	3	2	2	2	-
18	Co, мкг/л	0.2	1.13	0.27	0.33	-
19	Ni, мкг/л	<0.3	7.5	<0.3	2.9	-
20	Ga, мкг/л	0.02	<0.02	<0.02	<0.02	-
21	Mo, мкг/л	1.5	6.7	7.4	7.2	70
22	As, мкг/л	1.57	3.01	2.85	1.17	10
23	Se, мкг/л	4.4	11.7	6.8	5.3	40
24	Rb, мкг/л	2.62	0.75	0.24	0.32	-
25	Y, мкг/л	1.1	0.068	0.009	0.065	-
26	Zr, мкг/л	2.31	<0.05	<0.05	0.21	-
27	Nb, мкг/л	0.688	<0.005	<0.005	<0.005	-
28	Ag, мкг/л	<0.2	<0.2	<0.2	<0.2	-
29	Cd, мкг/л	<0.01	0.02	<0.01	0.03	3
30	In, мкг/л	<0.001	<0.001	<0.001	<0.001	-
31	Sn, мкг/л	0.3	<0.1	<0.1	<0.1	-
32	Sb, мкг/л	<0.2	<0.2	<0.2	<0.2	-
33	Te, мкг/л	<0.1	<0.1	<0.1	<0.1	-
34	Cs, мкг/л	0.07	0.033	<0.001	0.002	-
35	La, мкг/л	0.85	0.07	<0.01	0.04	-
36	Ce, мкг/л	1.2	<0.05	<0.05	<0.05	-
37	Pr, мкг/л	0.354	<0.006	<0.006	0.013	-
38	Nd, мкг/л	0.42	0.01	<0.01	0.02	-
39	Sm, мкг/л	0.29	0.003	<0.002	0.005	-
40	Eu, мкг/л	0.244	<0.001	<0.001	0.014	-
41	Gd, мкг/л	0.28	<0.003	<0.003	0.005	-
42	Tb, мкг/л	0.209	<0.002	<0.002	0.002	-
43	Dy, мкг/л	0.226	0.002	<0.001	0.006	-
44	Ho, мкг/л	0.173	<0.001	<0.001	0.003	-
45	Er, мкг/л	0.173	0.001	<0.001	0.005	-
46	Tm, мкг/л	0.122	<0.001	<0.001	0.001	-
47	Yb, мкг/л	0.15	<0.001	<0.001	0.004	-
48	Lu, мкг/л	0.107	<0.002	<0.002	0.003	-
49	Hf, мкг/л	0.118	<0.004	<0.004	0.052	-
50	Ta, мкг/л	0.924	0.005	0.008	0.015	-
51	W, мкг/л	8.85	<0.05	<0.05	0.16	-
52	Hg, мкг/л	<0.5	<0.5	<0.5	<0.5	1
53	Pb, мкг/л	<0.007	<0.007	<0.007	<0.007	-

#	Үзүүлэлт, нэгж	Дээжний нэр				MNS 0900:2018
		Зүүн худаг	Кемпийн ус	Нарангийн худаг	Нарангийн булаг	
54	Pb, мкг/л	<0.5	<0.5	<0.5	<0.5	-
55	Bi, мкг/л	<0.01	<0.01	<0.01	<0.01	-
56	Th, мкг/л	0.832	<0.002	<0.002	0.178	-
57	U, мкг/л	6.46	22.6	7.48	7.13	30

Эх сурвалж: Эс Жи Эс ИММЭ Монголиа лабораторийн үр дүн, 2025.12.02, 2025.12.18

Хайгуулын цооногоос шавхаж байгаа уснаас авсан дээжийг ЗГ-ын хэрэгжүүлэгч агетлаг Усны газрын Усны хяналтын төв лабораторид усны ерөнхий шинжилгээг хийлгэсэн. Цооногийн усыг шинжлэх тусдаа стандарт байхгүй тул шүүрлийн устай адилтган үзэж MNS 4943:2015 (Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Бохир ус. Ерөнхий шаардлага) стандартад заагдсан химийн үзүүлэлтүүд болон хүнд элементүүдийг шинжлүүлж, тус стандартын ЗДХ-тэй харьцуулан дараах хүснэгтэд үзүүлэв. Усны шинжилгээний үр дүнгээс үзэхэд өрөмдлөгийн цооногийн усны умбуур бодис, ХХХ, БХХ-ийн хэмжээ MNS 4943:2015 (Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Бохир ус. Ерөнхий шаардлага) стандартын ЗДХ-нээс их байна. Микробиологийн шинжилгээгээр гэдэсний бүлгийн эмгэг төрөгч илрээгүй.

Хүснэгт 18. Өрөмдлөгийн цооногийн усны ерөнхий шинжилгээний үр дүн

#	Шинжилсэн үзүүлэлт	Өрөмдлөгийн цооногийн ус	MNS 4943:2015 ЗДХ
1	pH	8.00	6.0-9.0
2	NH ₄ ⁺ , мг/л	3.82	-
3	Cl ⁻ , мг/л	3325.21	-
4	SO ₄ ²⁻ , мг/л	35.13	-
5	Умбуур бодис, мг/л	282.00	<30
6	ХХХ, мг/л	100.80	<50
7	БХХ, мг/л	38.77	<20
8	NO ₂ ⁻ , мг/л	0.01	-
9	NO ₃ ⁻ , мг/л	0.25	-
10	PO ₄ , мг/л	0.91	<1.5
11	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч	илрээгүй	илрэхгүй

Эх сурвалж: Усны газрын усны хяналтын төв лабораторийн үр дүн, 2025.12.12

Хайгуулын цооногоос шавхаж байгаа уснаас авсан сорьцонд хийсэн хүнд металлын шинжилгээний үр дүнг MNS 4943:2015 (Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Бохир ус. Ерөнхий шаардлага) стандарттай харьцуулан дараах хүснэгтэд үзүүлэв. Өрөмдлөгийн цооногийн усны хүнд металлын шинжилгээний дүнгээс үзэхэд хар тугалга, бари, стронцийн хэмжээ MNS 4943:2015 (Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Бохир ус. Ерөнхий шаардлага) стандартын ЗДХ-нээс их байна.

Хүснэгт 19. Өрөмдлөгийн цооногийн усны хүнд металлын шинжилгээний үр дүн

#	Шинжилсэн үзүүлэлт	Өрөмдлөгийн цооногийн ус	MNS 4943:2015
1	Mn, мг/л	0.0359	<0.5
2	Ni, мг/л	<0.005	<0.2
3	Cu, мг/л	0.0015	<1.0
4	As, мг/л	<0.005	<0.01
5	Co, мг/л	0.0148	<0.02
6	Pb, мг/л	0.2495	<0.1
7	Zn, мг/л	<0.005	<3.0
8	Fe, мг/л	<0.005	<1.0

#	Шинжилсэн үзүүлэлт	Өрөмдлөгийн цооногийн үс	MNS 4943:2015
9	Bi, мг/л	0.0982	-
10	Mo, мг/л	<0.005	<0.5
11	Te, мг/л	0.3867	-
12	Cd, мг/л	<0.005	<0.03
13	Se, мг/л	<0.005	<0.02
14	Al, мг/л	0.0346	<0.5
15	Li, мг/л	0.6125	-
16	Ba, мг/л	2.9198	<1.5
17	Ag, мг/л	0.0593	-
18	B, мг/л	0.1413	<0.5
19	Ga, мг/л	0.0775	-
20	Sr, мг/л	2.0720	<2.0
21	Tl, мг/л	<0.005	-
22	U, мг/л	0.0338	<0.05
23	V, мг/л	<0.005	<0.1
24	Be, мг/л	<0.0005	<0.001
25	Cr, мг/л	<0.005	<0.3


Эх сурвалж: Усны газрын усны хяналтын төв лабораторийн үр дүн, 2025.12.12

Хөрсөн бүрхэвчийн ОХШХ-ийн биелэлт

2025 оны БОМТ-нд хөрсний хяналт-шинжилгээг 6 цэгт хийхээр төлөвлөсөн ба ОХШХ-ийн биелэлтээр 7 цэгээс төлөвлөгдсөн дээжүүдийг авч, шинжлүүлсэн. Тухайлбал, хөрсний агрохимийн үзүүлэлтүүдийг ШУА-ийн харьяа Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн хөрсний лабораторид, хүнд металлын шинжилгээг Эс Жи Эс ИММЭ Монголиа ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид, хөрсний эрүүл ахуйн дээжийг Усны газрын Усны хяналтын Төв лабораторид тус тус шинжлүүлсэн.

Хүснэгт 20. Хөрсний хяналт-шинжилгээний төлөвлөгөө ба биелэлт

Төлөвлөгөө				Биелэлт		
Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Байршил	Хугацаа ба давтамж	ХШ-ний ажлын хэмжээ	Хяналт шинжилгээ хийсэн үзүүлэлт	Байршил	ХШ-ний ажлын хэмжээ
Хөрсний агрохими, хүнд металлын болон бактериологийн шинжилгээ	Хайгуулын цооногуудын орчмоос эрүүл газраас 2 цэгээс агрохими, 3 цэгээс хүнд металл, Хайгуулын кемпээс 1 цэгээс бактериологи	Жилд 1 удаа мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ	6 цэгт	Хөрсний агрохими, хүнд металлын дээжийг тус бүр 3 цэгээс, бактериологийн дээжийг 1 цэгээс авч, шинжлүүлсэн	-Хайгуулын кемп 1 цэгт Хайгуулын талбайд 6 цэгээс	7 цэг*7 дээж*1 удаа



Зураг 20. Хөрсний хяналт-шинжилгээ хийсэн цэгүүд

Хөрсний дээжлэлт-1


Байршил	Хайгуулын талбайн зүүн урд хэсэгт, хэвтээ цооног өрөмдсөн талбайн баруун талд тэгш газар хийв.
Солбицол	Уртраг: 105° 24' 50.76" Өргөрөг: 43° 37' 44.68" өндөр: 1515 м
Гадаргын налуу	3 градус
Гадаргын чулуу	20%
Ургамалжилт	Хармаг, бударгана, таана зонхилон ургасан.



Гэрэл зураг 21. Хөрсний агрохимийн болон хүнд металлын дээж авсан цэг

Хөрсний дээжлэлт-2

Байршил	Хайгуулын талбайн баруун урд хэсэгт эрүүл газар хийв.
Солбицол	Уртраг: 105° 20' 59.06" өргөрөг: 43° 37' 38.64" өндөр: 1520 м
Гадаргын налуу	3 градус
Гадаргын чулуу	60%
Ургамалжилт	Хялгана, таана, хазаар өвс



Гэрэл зураг 22. Хөрсний агрохимийн болон хүнд металлын дээж авсан цэг

Хөрсний дээжлэлт-3

Байршил	Нарийн хар уулын урд бэлд эрүүл газар
Солбицол	Уртраг: 105° 20' 6.78" Өргөрөг: 43° 38' 35.10" өндөр: 1555 м
Гадаргын налуу	10 градус
Гадаргын чулуу	95%
Ургамалжилт	Баглуур зонхилно.



Гэрэл зураг 23. Хөрсний агрохимийн болон хүнд металлын дээж авсан цэг

Хөрсний хяналт-шинжилгээний үр дүн

Хөрсний дээжүүдэд хийсэн лабораторийн шинжилгээний үр дүнгээс үзэхэд Sp-1 (6-30), Sp-2 (12- 30, 30-50) хүчтэй шүлтлэг, бусад дээж шүлтлэг урвалын орчинтой, Sp- 2 (12-30) бага зэрэг карбонаттай, Sp-2 (30-50) хүчтэй карбонатлаг, бусад дээж дунд зэрэг карбонатлаг, бусад дээж дунд зэрэг карбонатлаг, ялзмагийн агууламжаар

бага, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон хөдөлгөөнт калийн хангамжаар багатай хөрс байна. Хайгуулын талбайд тархсан хөрс нь үржил шимийн ерөнхий түвшин багатай болохыг илтгэж байна.

Хүснэгт 21. Хөрсний химийн үзүүлэлтүүд

#	Дээжний дугаар	Гүн, см	pH _{H2O} (1:5)	CaCO ₃ %	Ялзмаг %	e _{c5} dS/m	Хөдөлгөөнт, мг/100г	
							p _{2O5}	K _{2O}
1	Sp-1	0-6	8.75	5.73	0.568	0.182	1.62	10.3
2		6-30	9.35	2.91	0.741	0.525	0.28	10.5
3	Sp-2	0-12	8.89	3.71	0.578	0.139	0.29	14.5
4		12-30	9.19	1.36	0.645	0.239	0.39	15.6
5		30-50	9.24	15.81	0.730	0.445	0.18	11.1
6	SP-3	0-8	8.67	4.36	1.182	0.476	0.54	16.8

Эх сурвалж: ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, Хөрсний лабораторийн шинжилгээний үр дүн, 2025.12.10

Хяналт-шинжилгээний цэгүүдийн хөрсний дээжүүдэд хийсэн лабораторийн шинжилгээний үр дүнгээс үзэхэд хайгуулын талбайд тархсан хөрсөн бүрхэвчийн SP-2 зүсэлтийн дээж элсэнцэр, SP1 зүсэлтийн 6-30 см, SP-3 зүсэлтийн дээж элсэрхэг шавранцар механик бүрэлдэхүүнтэй байна.

Хүснэгт 22. Хөрсний механик бүрэлдэхүүн

#	Дээжний дугаар	Гүн, см	Ширхэгийн хэмжээ, % (мм-ээр)			Механик бүрэлдэхүүн
			Элс (2-0.05)	Тоос (0.05-0.002)	Шавар (< 0.002)	
1	Sp-1	0-6	78.2	9.9	11.9	Элсэнцэр
2		6-30	51.5	16.8	31.7	Элсэрхэг шавранцар
3	Sp-2	0-12	61.1	21.0	17.9	Элсэнцэр
4		12-30	58.2	23.9	17.9	Элсэнцэр
5		30-50	68.1	13.9	18.0	Элсэнцэр
6	SP-3	0-8	58.3	19.9	21.8	Элсэрхэг шавранцар

Эх сурвалж: ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, Хөрсний лабораторийн шинжилгээний үр дүн, 2025.12.10

Хайгуулын талбайн хөрсний хүнд металлын дээжийг 3 цэгийн хөрсний өнгөн хэсэг (0-5 см гүн)-ээс, хөрсний эрүүл ахуйн дээжийг 1 цэгээс тус тус авсан.

Хүснэгт 23. Хөрсний хүнд металлын болон бактериологийн дээж авсан цэгүүд

#	Хяналт-шинжилгээний цэгийн дугаар	Хяналт-шинжилгээний байршил	Өргөрөг	Уртраг
1	SHM-1	Хэвтээ цооног өрөмдсөн талбайн баруун талд эрүүл газар	105° 24' 50.76	43° 37' 44.684
2	SHM-2	Улаан нуурын баруун хойд хөндийд эрүүл газар	105° 20' 59.06"	43° 37' 38.64"
3	SHM-3	Талбайн баруун хойд хэсэгт Нарийн хар уулын урд бэлд эрүүл газар	105° 20' 6.78"	43° 38' 35.10"
Хөрсний бактериологийн дээж авсан цэг				
1	SBC01	МГР кэмгийн хашаанд, эрүүл газар	43° 38' 30.4"	105° 23' 8.5"

Хөрсний дээжүүдэд хүнд металлын агууламжийг Эс Жи Эс ИММЭ Монголиа ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн бөгөөд үр дүнг MNS 5850:2019 (Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ) стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээ (ЗДХ)-тэй харьцуулан дараах хүснэгтэд үзүүллээ.

Лабораториудын шинжилгээний үр дүнгүүдээс үзэхэд хайгуулын талбайгаас авсан 3

дээжин дэх хүнд элементүүдийн агууламж MNS 5850:2019 стандартад тогтоосон хүнд металлуудын зөвшөөрөгдөх дээд хэмжээ болон хортой, аюултай агууламжаас бага байна.

Хүснэгт 24. Хөрсний хүнд металлын шинжилгээний үр дүн

Элемент	Хэмжих нэгж	Дээжний нэр			MNS 5850:2019		
		SHM-1	SHM-2	SHM-3	ЗДХ	Хортой агууламж	Аюултай агууламж
Ag	ppm	<2	<2	<2			
Al	%	5.38	6.17	8.2			
As	ppm	14	14	14	20	50	100
Ba	ppm	925	649	684			
Be	ppm	1.2	1.4	1.1			
Bi	ppm	<5	<5	<5			
Ca	%	1.01	1.11	2.9			
Cd	ppm	<1	<1	<1	3	10	20
Co	ppm	10	10	11	50	500	1000
Cr	ppm	32	42	50	150	400	1500
Cu	ppm	31.9	33.6	34.3	100	500	1000
Fe	%	3.48	3.46	4.27			
K	%	1.75	2.22	1.94			
La	ppm	14.5	18.4	13			
Li		24	28	38			
Mg	%	0.76	1.02	1.57			
Mn	ppm	648	798	707			
Mo	ppm	<1	<1	<1	5	20	50
Na	%	2.31	2.19	3.01			
Ni	ppm	19	25	25	150	1000	1800
P	ppm	0.06	0.08	0.07			
Pb	ppm	3	9	<2	100	500	1200
S	%	0.06	0.06	0.08			
Sb	ppm	9	10	7			
Sc	ppm	8.7	10.2	15			
Sn		<10	<10	<10			
Sr	ppm	236	236	305	800	3000	6000
Ti	%	0.33	0.35	0.34			
V	ppm	74	82	115	150	600	1000
W	ppm	<10	<10	<10			
Zn	ppm	70	75	87	300	600	1000
Y	ppm	15.8	16.5	19.1			
Zr	ppm	87.2	82.8	89.2			

Эх сурвалж: Эс Жи Эс ИММЭ Монголиа ХХК-ийн лабораторийн шинжилгээний үр дүн 2025.11.30
Тайлбар: ppm нь мг/кг-тай адил утгатай хэрэглэнэ.

МГР кэмийн хашаан дотроос хөрсний бактериологийн (эрүүл ахуйн) дээж авч Усны хяналтын төв лабораторид шинжлүүлсэн ба шинжилгээний үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 25. Хөрсний бактериологийн шинжилгээний үр дүн

Дээжний дугаар	Гэдэсний савханцрын таньц		Перфрингенс титр		Эмгэгтөрөгч нян	
	MNS 5367:2004	Шаардлага	MNS 6341:2012	Шаардлага	Шинжилгээний дүн	Шаардлага
SBac-1	> 0.0001 Их бохирдолтой	> 0.1	≥ 0.01 Бага бохирдолтой	≥ 0.1	Илрээгүй	1 гр-д илрэхгүй


Хөрсөнд гэдэсний савханцрын бохирдол илэрсэн тул нийт ажилчид хувийн ариун цэврийг сайтар сахиж ажиллах хэрэгтэй. Гэдэсний савханцраар халдварласан үед гэдэс гүйлгэх, усан эсвэл цустай суулгалт, хэвлийн өвдөлт, халууралт зэрэг шинж тэмдэг илэрдэг.

Ургамлан нөмрөгийн ОХШХ-ийн биелэлт

Ургамлан нөмрөгийн хяналт-шинжилгээг өрөмдлөг хийх цооногийн талбайг төлөөлүүлэн 1 цэгт хийхээр төлөвлөсөн, харин ОХШХ-ийн биелэлтээр төлөвлөсөн 1 цэгт болон өмнө жилүүдэд хийсэн цэгүүдэд давтан хийсэн.

Хүснэгт 26. Ургамлан нөмрөгийн хяналт-шинжилгээний төлөвлөлт ба биелэлт

Төлөвлөгөө				Биелэлт		
Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Байршил	Хугацаа ба давтамж	ХШ-ний ажлын хэмжээ	Хяналт шинжилгээ хийсэн үзүүлэлт	Байршил	ХШ-ний ажлын хэмжээ
Өрөмдлөг хийх талбайн ургамлын зүйлүүдийг бүртгэж баримтжуулна	Өрөмдлөг хийх цооногийн талбайг төлөөлөх 1 цэгт	Жилд 1 удаа мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ	1 цэгт	Ургамлын зүйлийн бүрдэл Арви Бүрхэц Доройтлын шатлал	Хайгуулын талбайд 15 цэгт	15 цэг*1 удаа



Зураг 24. Ургамлын хяналт-шинжилгээ хийсэн байршил

Ургамлын хяналт-шинжилгээг нийт 15 цэгт хийсэн ба 10x10 м талбай бүрт ургамлын зүйлүүдийг бүртгэж, зүйлүүдийн арвийг Друде-ийн шатлалыг ашиглан үнэлсэн (**Хүснэгт 27**). Мөн 1x1 м талбайн ургамлын, чулууны, халцгай газрын бүрхцийг үнэлсэн. Бичиглэл хийсэн цэг бүрийн ургамлажилтын нөхцлийг Keighery (1994)-ийн боловсруулсан ангиллын схемийг ашиглан үнэлсэн (**Хүснэгт 28**).



Гэрэл зураг 25. Ургамлын хяналт-шинжилгээ хийсэн талбайнууд (10x10м, 1x1м)

Хүснэгт 27. Ургамлын зүйлүүдийн арвийг үнэлсэн Друде-ийн шатлал


Ангилал	Тодорхойлолт
Un +	Талбайд зөвхөн ганц нэг тохиолдоно
Rr<1	Талбайд маш ховор тохиолдоно
So1 1	Талбайд маш цөөн тоогоор буюу бүлгэмдэлд 1%-иас бага тохиолдоно
Sp (1-10%)	Талбайд тус зүйлийн бүрхэц 1-10%-ийн хооронд буюу таруу
Сор1 (10-25%)	Талбайд тус зүйлийн бүрхэц 10-25%-ийн хооронд
Сор2 (25-50%)	Талбайд тус зүйлийн бүрхэц 25-50%-ийн хооронд
Сор3 (50-100%)	Талбайд тус зүйлийн бүрхэц 50-100%-ийн хооронд
Сос (100%)	Талбайд тус зүйлийн бүрхэц 100% хүртэл

Хүснэгт 28. Ургамалжилтын нөхцлийг үнэлсэн Keighery (1994)-ийн ангиллын схем

Ангилал	Тодорхойлолт
Онгон (1)	Онгон байгалиараа эсвэл бараг онгон. Сөрөг нөлөөлөлд өртсөн шинж тэмдэг ажиглагдаагүй
Онц сайн (2)	Ургамлын бүтэц бүрэн хадгалагдсан. Хэрэв сөрөг нөлөө байгаа бол зөвхөн нөлөөлөлд ойр зүйлүүдэд нөлөөлсөн байна. Хэрэв хөл газрын ургамал байгаа бол тэдгээр нь түрэмгий биш зүйлүүд байна.
Маш сайн (3)	Ургамалжилтын бүтэцэд өөрчлөлт орсон. Тодорхой сөрөг нөлөөллийн үл мөр илэрсэн. Жишээлбэл, давтамжтай гал түймэр, хөл газрын ургамлууд түрж ургасан, хөрсний өвчин үүсгэгчид, мод бэлтгэл болон мал бэлчээрлэлтээс шалтгаалж ургамалжилтын бүтэцэд өөрчлөлт орсон.
Сайн (4)	Ургамлын бүтэц олон удаагийн сөрөг нөлөөллөөс шалтгаалан мэдэгдэхүйцээр өөрчлөгдсөн боловч үндсэн бүтэц хадгалах эсвэл дахин сэргээх чадвартай хэвээр байна. Жишээлбэл: олон удаагийн давтамжтай гал түймэр, хөл газрын ургамлууд өндөр нягтшилтай тархсан, хэсэгчилсэн цэвэрлэгээ, хаталт, мод бэлтгэл болон мал бэлчээрлэлтийн нөлөөгөөр ургамлын бүтэцэд өөрчлөлт орсон.
Доройтсон (5)	Ургамалжилтын үндсэн бүтэц сөрөг нөлөөллөөс шалтгаалан ихэд алдагдсан. Эргэж нөхөн сэргэх боломж байгаа ч эрчимтэй менежментгүйгээр сайн төлөвт ойртох боломжгүй. Жишээлбэл: давтамжтай гал түймэр, хөл газрын ургамал өндөр нягтшилтай түрж ургасан байдал, хэсэгчилсэн цэвэрлэгээ, хаталт, мод бэлтгэл болон мал бэлчээрлэлтийн нөлөөгөөр ургамалжилтын бүтэц алдагдсан.
Бүрэн доройтсон (6)	Ургамалжилтын бүтэц бүрэн алдагдсан бөгөөд тухайн газар нутгийн уугуул ургамал бараг байхгүй буюу бүрэн устсан. Ийм газруудыг ихэвчлэн “цэцэрлэгт хүрээлэнгийн цэвэрлэгдсэн талбай” гэж тодорхойлдог бөгөөд тус бүсэд ургамлын бүрдэл нь гол төлөв хөл газрын ургамал эсвэл тариалангийн ургамлаас бүрдсэн, цөөн тооны тусгаарлагдсан уугуул мод эсвэл бут сөөгүүд үлдсэн байдаг.

Ургамлан нөмрөгийн хяналт-шинжилгээний үр дүн


Ургамлын хяналт-шинжилгээний 15 цэгийн хээрийн бичиглэлийн үр дүнд нийт 15 овог 28 төрөл 32 зүйл гуурст ургамал бүртгэгдсэн (**Хүснэгт 29**). Эдгээр ургамлын зүйлүүдийг үйл ажиллагааны бүлгээр ангилсан ба 5 зүйл үетэн, 1 зүйл улалж, 17 зүйл алаг өвс, 9 зүйл сөөг ургамал байна (**Дүрслэл 2.9**) Мөн олон наст ургамал 25 зүйл, хоёр наст ургамал 1 зүйл, нэг наст ургамал 6 зүйл тохиолдсон байна.



Дүрслэл 3.9 Ургамлын зүйлүүдийн үйл ажиллагааны бүлгийн ангилал

МУ-ын Байгалийн ургамлын тухай хууль (1995)-ийн хавсралт, Нэн ховор ургамлын болон Засгийн газрын 1995 оны 153 болон 2004 оны 165 дугаар тогтоолын хавсралт Ховор ургамлын жагсаалтад бүртгэгдсэн нэн ховор болон ховор зүйл тохиолдоогүй болно.

Хайгуулын талбайд ургамлын хяналт-шинжилгээ хийсэн 15 талбайн дунджаар ургамалжилтын нөхцөл 53% нь Сайн, 47% нь Доройтсон гэж үнэлэгдсэн байна. Мөн газрын гадаргын бүрхцийг бичиглэл хийсэн 15 талбайн дунджаар авч үзвэл ургамлын бүрхэц 27%-ийг, чулуу 16%-ийг, халцгай газар 57%-ийг бүрдүүлж байна (**Дүрслэл 2.10**).



Дүрслэл 3.10 Ургамлын бичиглэл хийсэн талбайнуудын ургамалжилтын нөхцөл ба дундаж бүрхэц

Хүснэгт 29. Ургамлын хяналт-шинжилгээний үзүүлэлтүүд

Цэгийн дугаар	Ургамалжилтын нөхцөл (Keighery, 1994)	10 x10 м талбайд бүртгэгдсэн зүйлүүд	Арви (Drude's scale)	1x1м талбай дахь бүрхэц
VEG-01	Сайн	<i>Salsola passerine</i> <i>Reamauria soongarica</i> <i>Allium polyrrhizum</i> <i>Kalidium gracile</i> <i>Anabasis brevifolia</i> <i>Nitraria sibirica</i> <i>Chloris virgata</i> <i>Artemisia pectinata</i> <i>Stipa gobica</i> <i>Cleistogenes songorica</i>	Cop3 Cop3 Cop2 Cop2 Sp Cop2 Sp Cop1 Sp Sp	Ургамлан бүрхэц 55% Чулуу 25% Халцгай газар 20%
VEG-02	Сайн	<i>Reamauria soongarica</i> <i>Salsola passerine</i> <i>Allium polyrrhizum</i> <i>Anabasis brevifolia</i> <i>Stipa gobica</i> <i>Artemisia pectinata</i>	Cop3 Cop3 Cop2 Sp Sp Sp	Ургамлан бүрхэц 35% Чулуу 45% Халцгай газар 20%
VEG-03	Доройтсон	<i>Achnatherum splendens</i> <i>Nitraria sibirica</i> <i>Carex duriuscula</i> <i>Salsola passerine</i> <i>Reamauria soongarica</i> <i>Kalidium gracile</i> <i>Artemisia pectinata</i>	Cop3 Cop2 Cop3 Sp Sp Sol Sp	Ургамлан бүрхэц 35% Чулуу 45% Халцгай газар 20%
VEG-04	Доройтсон	<i>Anabasis brevifolia</i> <i>Allium polyrrhizum</i> <i>Salsola passerine</i> <i>Artemisia pectinata</i> <i>Eurotia ceratoides</i> <i>Caragana leucophloea</i> <i>Stipa gobica</i>	Cop3 Cop3 Sp Cop1 Sp Sol Sp	Ургамлан бүрхэц 25% Чулуу 45% Халцгай газар 30%
VEG-05	Сайн	<i>Allium polyrrhizum</i> <i>Anabasis brevifolia</i> <i>Stipa gobica</i> <i>Micropeplis arachnoidea</i> <i>Halogeton glomeratus</i>	Cop2 Cop2 Sp Sp Sp	Ургамлан бүрхэц 25% Чулуу 10% Халцгай газар 65%
VEG-06	Сайн	<i>Allium polyrrhizum</i> <i>Anabasis brevifolia</i> <i>Stipa gobica</i> <i>Micropeplis arachnoidea</i> <i>Halogeton glomeratus</i> <i>Aristida Heymannii</i>	Cop2 Cop2 Sp Sp Sp Sol1	Ургамлан бүрхэц 30% Чулуу 15% Халцгай газар 55%
VEG-07	Сайн	<i>Allium polyrrhizum</i> <i>Salsola passerine</i> <i>Reamauria soongarica</i> <i>Anabasis brevifolia</i> <i>Cleistogenes songorica</i> <i>Eragrostis minor</i> <i>Peganium nigellastrum</i>	Cop2 Cop2 Cop1 Sp Sp Sol-1 Sol-1	Ургамлан бүрхэц 30% Чулуу 5% Халцгай газар 65%
VEG-08	Доройтсон	<i>Allium polyrrhizum</i> <i>Anabasis brevifolia</i> <i>Stipa glareosa</i>	Cop1 Sp Sp	Ургамлан бүрхэц 10% Чулуу 5% Халцгай газар 85%

Цэгийн дугаар	Ургамалжилтын нөхцөл (Keighery, 1994)	10 x10 м талбайд бүртгэгдсэн зүйлүүд	Арви (Drude's scale)	1x1м талбай дахь бүрхэц
		<i>Micropeplis arachnoidea</i> <i>Peganium nigellastrum</i>	Sol-1 Sol-1	
VEG-09	Доройтсон	<i>Allium polyrrhizum</i> <i>Salsola passerine</i> <i>A.mongolicum</i> <i>Micropeplis arachnoidea</i> <i>Halogeton glomeratus</i> <i>Anabasis brevifolia</i> <i>Cleistogenes songorica</i>	Cop2 Cop2 Sp Sp Sp SP Un+	Ургамлан бүрхэц 18% Чулуу 5% Халцгай газар 77%
VEG-10	Сайн	<i>Allium polyrrhizum</i> <i>Salsola passerine</i> <i>Reamauria soongarica</i> <i>Anabasis brevifolia</i> <i>Micropeplis arachnoidea</i> <i>Atraphaxis pungens</i>	Cop2 Cop1 Cop1 Sp Sp Sp	Ургамлан бүрхэц 30% Чулуу 10% Халцгай газар 60%
VEG-11	Сайн	<i>Allium polyrrhizum</i> <i>Salsola passerine</i> <i>Ajania achilleoides</i> <i>Anabasis brevifolia</i> <i>Convolvulus ammanii</i> <i>Cleistogenes songorica</i> <i>Micropeplis arachnoidea</i> <i>Peganium nigellastrum</i>	Cop2 Cop1 Sp Sp Sp Sp Sp Sp	Ургамлан бүрхэц 30% Чулуу 5% Халцгай газар 65%
VEG-12	Доройтсон	<i>Allium polyrrhizum</i> <i>Salsola passerine</i> <i>Eragrostis minor</i> <i>Reamauria soongarica</i> <i>Anabasis brevifolia</i> <i>Ajania achilleoides</i> <i>Micropeplis arachnoidea</i>	Cop2 Cop2 Cop1 Sp Sp Sol1 Sol1	Ургамлан бүрхэц 15% Чулуу 5% Халцгай газар 80%
VEG-13	Доройтсон	<i>Salsola passerine</i> <i>Cleistogenes songorica</i> <i>Allium polyrrhizum</i> <i>Atraphaxis pungens</i> <i>Reamauria soongarica</i> <i>Halogeton glomeratus</i> <i>Micropeplis arachnoidea</i>	Cop2 Cop2 Cop1 Sp Sp Sol1 Sol1	Ургамлан бүрхэц 10% Чулуу 15% Халцгай газар 75%
VEG-14	Сайн	<i>Peganium nigellastrum</i> <i>Chenopodium album</i> <i>Micropeplis arachnoidea</i> <i>Halogeton glomeratus</i> <i>Chloris virgata</i>	Cop3 Cop2 Sp Sp Rr<1	Ургамлан бүрхэц 40% Чулуу 0% Халцгай газар 60%
VEG-15	Доройтсон	<i>Allium polyrrhizum</i> <i>Salsola passerine</i> <i>Eragrostis minor</i> <i>Anabasis brevifolia</i> <i>Cleistogenes songorica</i> <i>Atraphaxis pungens</i> <i>Micropeplis arachnoidea</i> <i>Halogeton glomeratus</i>	Cop1 Cop1 Sp Sp Sp Sp Sol1 Sol	Ургамлан бүрхэц 15% Чулуу 2% Халцгай газар 83%

Тайлбар: Ургамлын зүйлийн арви (Drude's scale)- Нэлэнхий тархсан Soc 100%, Арвин Cop3 50-100%, Элбэг Cop2 25-50%, Элбэгдүү Cop1 10-25%, Таруу Sp 1-10%, Маш ховор Rr<1, Ганц нэг Un+

Амьтны аймгийн ОХШХ-ийн биелэлт

Амьтны аймгийн хяналт-шинжилгээг 2025 оны БОМТ-нд тусгагдсаны дагуу хайгуулын талбайн бүх амьдрах орчинд мөлхөгч, хөхтөн, шувуудын хээрийн ажиглалт, судалгааг хийв.

Хүснэгт 30. Амьтны аймгийн хяналт-шинжилгээний төлөвлөлт ба биелэлт

Төлөвлөгөө				Биелэлт		
Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Байршил	Хугацаа ба давтамж	ХШ-ний ажлын хэмжээ	Хяналт шинжилгээ хийсэн үзүүлэлт	Байршил	ХШ-ний ажлын хэмжээ
Шувуу, хөхтөн, мөлхөгч амьтдын зүйлийн нэр, бодгалийн тоо, тохиолдсон ул мөр, гэрэл зураг, байршлын координат	Хайгуулын талбайн тэгш тал, уул, толгод гэх мэт бүхий л амьдрах орчинд	Жилд 1 удаа мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ	1 удаа	Мөлхөгч, шувуу, хөхтөн амьтдын ажиглалт, судалгааг хийж, зүйлийн нэр, бодгалийн тоо, тохиолдсон ул мөр, гэрэл зураг, байршлын координатыг тэмдэглэсэн	Хайгуулын талбайн бүхий л амьдрах орчинд	1 удаа

Хүснэгт 31. Амьтны аймгийн хээрийн ажиглалт судалгаа хийсэн аргазүй

Амьтны анги	Судалгааны аргазүй
Мөлхөгч	Ажиглалт хийж, тэмдэглэх, зургийг нь авах
Шувуу	Дурангаар харах, зураг авах, тоолох, ажиглах, тэмдэглэх
Жижиг хөхтөн	Нүхийг ажиглаж зураг авах, амьд баригчаар барьж, тавих
Том хөхтөн	Дурандах, зураг авах, уст цэгээр ажиглах аман мэдээ авах

Амьтны аймгийн хяналт-шинжилгээний ажиглалт, судалгаагаар тохиолдсон мөлхөгч, хөхтөн болон шувуудын зүйлийн бүрдлийг гаргаж, Монгол улсын Мөлхөгч (Тэрбиш ба бусад, 2006), Шувуу (Гомбобаатар ба бусад, 2011), Хөхтөн амьтны (Clark et al, 2006) Улаан дансыг ашиглан амьтдыг Улаан дансны ангилал болох ДБХХ (IUCN, 2025.1)-ны болон Бүс нутгийн үнэлгээгээр ангилав. Мөн Зэрлэг амьтан ба ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ийн хавсралтууд болон Амьтны тухай хууль (2012)-иар нэн ховор, ЗГ-ын 7 дугаар тогтоол (2012)-ын 1 дүгээр хавсралтад багтсан ховор амьтан тохиолдсон эсэхийг шалгав.

Амьтны аймгийн хяналт-шинжилгээний үр дүн

Мөлхөгч

Мөлхөгчдийн хувьд Цоохор хонин гүрвэл *Phrynocephalus versicolor* болон Могой гүрвэл *Eremias multiocellata* гэсэн 2 зүйл тохиолдсон. Эдгээрээс судалгааны талбайд Цоохор хонин гүрвэл *Phrynocephalus versicolor* түгээмэл ажиглагдсан бол Могой гүрвэл *Eremias multiocellata* 2 байршилд ажиглагдсан байна (Хүснэгт 32).

Хүснэгт 32. Амьтны хяналт-шинжилгээгээр ажиглагдсан мөлхөгчдийн байршил, бодгалийн тоо

#	Зүйлийн нэр	Илрүүлсэн арга техник	Тохиолдсон бодгалийн тоо	Тохиолдсон байршлын солбицол	
				ХӨ	ЗУ
1	Цоохор хонин гүрвэл- <i>Phrynocephalus versicolor</i>	Ажиглагдсан/Гүйж	1	43° 37' 42.700	105° 23' 16.06
		Ажиглагдсан/Гүйж	1	43° 38' 14.110	105° 20' 48.56
		Ажиглагдсан/Гүйж	1	43° 38' 2.870"	105° 22' 52.06
		Ажиглагдсан/Гүйж	1	43° 38' 21.040	105° 23' 47.29
		Ажиглагдсан/Гүйж	1	43° 37' 6.660"	105° 20' 46.22
2	Могой гүрвэл- <i>Eremias multiocellata</i>	Ажиглагдсан/Гүйж	1	43° 37' 42.700	105° 23' 16.06
		Ажиглагдсан/Гүйж	1	43° 37' 37.430	105° 22' 6.020

Гэрэл зураг 26. Амьтны аймгийн хяналт-шинжилгээгээр ажиглагдсан мөлхөгчид



Цоохор хонин гүрвэл *Phrynocephalus versicolor*



Могой гүрвэл *Eremias multiocellata*

Шувууд

2025 оны амьтны хяналт-шинжилгээний хээрийн ажиглалтаар нийт 13 зүйл шувуу бүртгэгдсэн ба эдгээрээс Эвэрт болжмор *Eremophila alpestris*, Монгол болжмор *Melanocorypha mongolica* болон Хээрийн бор шувуу *Passer montanus* түгээмэл тохиолдсон байна (Хүснэгт 33).

Хүснэгт 33. Амьтны хяналт-шинжилгээгээр ажиглагдсан шувууд


#	Зүйлийн нэр	Илрүүлсэн арга техник/үл мөр	Тохиолдсон бодгалийн тоо	Тохиолдсон байршлын солбицол	
				ХӨ	ЗУ
1	Эвэрт болжмор <i>Eremophila alpestris</i>	Ажиглалт/нисэж	1	43°39'6.170"	105°24' 29.49
		Ажиглалт/нисэж	3	43°36'7.836"	105°20' 44.45
		Ажиглалт/сүүж	50	43°39'0.340"	105°21' 50.60
		Ажиглалт/нисэж	5	43°37'14.400	105°24'10.90
		Ажиглалт/сүүж	2	43.628550	105.413529
		Ажиглалт/нисэж	20	43.636628	105.380645
		Ажиглалт/нисэж	60	43.641061	105.322617
		Ажиглалт/сүүж	5	43.645352	105.337937
		Ажиглалт/нисэж	70	43.611165	105.353669
2	Шилийн сар <i>Buteo hemilasius</i>	Ажиглалт/нисэж	1	43°35'58.711	105°19' 56.16

#	Зүйлийн нэр	Илрүүлсэн арга техник/ул мөр	Тохиолдсон бодгалийн тоо	Тохиолдсон байршлын солбицол	
				ХӨ	ЗУ
3	Цармын бүргэд <i>Aquila chrysaetos</i>	Ажиглалт/сүүж	1	43°36'59.19"	105°22'52.09"
4	Хон хэрээ <i>Corvus corone</i>	Ажиглалт/сүүж	1	43.628550	105.413529
		Ажиглалт/нисэж	1	43.645630	105.338364
		Ажиглалт/сүүж	1	43°38'32.800	105°23'8.000
		Ажиглалт/нисэж	1	43°35'59.941	105°19' 23.96
5	Хээрийн бор шувуу <i>Passer montanus</i>	Ажиглалт/сүүж	50	43.628607	105.414491
		Ажиглалт/нисэж	5	43.628559	105.415083
		Ажиглалт/сүүж	4	43°38'32.8"	105°23'8.0"
6	Начин шонхор <i>Falco tinnunculus</i>	Ажиглалт/нисэж	1	43.628607	105.414491
7	Цөлийн чогчиго <i>Oenanthe deserti</i>	Ажиглалт/гүйж	2	43°37'21.28"	105°24'10.79"
8	Хөхвөр тагтаа <i>Columbia vivia</i>	Ажиглалт/сүүж	12	43°38'30.61"	105°23'14.48"
		Ажиглалт/сүүж	5	43.628559	105.415083
9	Хадны тагтаа <i>Columba rupestris</i>	Ажиглалт/сүүж	6	43.613724	105.340916
10	Бөөвөлжин өвөөлж <i>Upupa epops</i>	Ажиглалт/сүүж	1	43°37'26.13"	105°24'43.52"
11	Нөмрөг тас <i>Aegypius monachus</i>	Ажиглалт/сүүж	5	43°37'05.02"	105°22'41.61"
		Ажиглалт/сүүж	5	43.645630	105.338364
12	Монгол болжмор <i>Melanocorypha mongolica</i>	Ажиглалт/сүүж/нисэж	87	43.641061	105.322617
13	Монгол ногтруу <i>Syrrhaptes paradoxus</i>	Ажиглалт/сүүж	3	43.620159	105.341149

Гэрэл зураг 27. Амьтны аймгийн хяналт-шинжилгээгээр ажиглагдсан шувууд



Эвэрт болжмор- *Eremophila alpestris*



Цармын бүргэд *Aquila chrysaetos*



Эвэрт болжмор *Eremophila alpestris*



Хадны тагтаа *Columba rupestris*



Хээрийн бор шувуу *Passer montanus*
Хэвтээ ерөмдлөгийн хашааны гадна



Хон хэрээ *Corvus corone*



Монгол болжмор *Melanocorypha mongolica* (Нарангийн булаг дээр)





Нөмрөг тас *Aegypius monachus* (Чулуун, Бямбаа нарын өвөлжөөний зүүн талд, хад чулуурхаг ууланд)

Хөхтөн амьтад

Амьтны хяналт-шинжилгээний ажиглалт, судалгаагаар нэг зүйл шөнийн идэвхит мэрэгч болох Дэлдэн зараа *Hemiechinus auritus*, 3 зүйл жижиг хөхтөн Шар үнэг *Vulpes vulpes*, Бор туулай *Lepus tolai*, Морин чичүүл *Rhombomys opimus* буюу нийт 4 зүйл хөхтөн тохиолдсон.

Хүснэгт 34. Амьтны аймгийн хяналт-шинжилгээгээр ажиглагдсан хөхтөн амьтдын мэдээлэл

#	Зүйлийн нэр	Илрүүлсэн арга техник/ул мөр	Тохиолдсон бодгалийн тоо	Тохиолдсон байршлын солбицол	
				ХӨ	ЗУ
1	Дэлдэн зараа <i>Hemiechinus auritus</i>	Шөнийн ажиглалт/гүйж	2	43°38'32.43"	105°23'9.97"
2	Морин чичүүл <i>Rhombomys opimus</i>	Ажиглалт/Нүхэн дээрээ сууж	10	43°36'10.06"	105°22'50.78"
		Ажиглалт/Нүхэн дээрээ сууж	10	43.618976	105.341268
		Ажиглалт/Нүхэн дээрээ сууж	20	43.603010	105.381311
3	Шар үнэг <i>Vulpes vulpes</i>	Ажиглалт/Гүйж	1	43.646184	105.340011
4	Бор туулай <i>Lepus tolai</i>	Ажиглалт/хярж	1	43.642333	105.385167

Гэрэл зураг 28. Амьтны аймгийн хяналт-шинжилгээгээр ажиглагдсан хөхтөн амьтад



Шар үнэг *Vulpes vulpes*

Хэвтээ өрөмдлөгийн талбайн зүүн хойно




Бор түүлай *Lepus tolai*

Кемпийн хашаанд



Морин чичүүл *Rhombomys opimus* Мөнхболдын өвөлжөөний зүүн хойд талд Хармаг-Бударгана бүхий хотгорт





Зураг 29. Амьтны хяналт-шинжилгээгээр ажиглагдсан амьтдын тохиолдсон байршил

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны БОХТ-ний биелэлтийн тайланг цахимаар буюу БОУАӨЯ-ны Байгаль орчны мэдээллийн сангийн БОМТ-ний биелэлтийн тайлан ([Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, биелэлтийн тайлан \(eic.mn\)](#)) хэсэгт холбогдох мэдээллийн хамт оруулж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журамд заасан хугацаа (11-р сарын 1-ний дотор)-нд илгээсэн.

Хүснэгт 35. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлт

#	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хэрэгжилт
1	Хайгуулын ажил гүйцэтгэж буй талбай орчимд нутагладаг Цагаан-Овоо багийн иргэд	Багийн иргэдийн нийтийн хуралд танилцуулах	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, биелэлтийн явцыг танилцуулах	Багийн иргэдийн нийтийн хуралд 2024 онд 1 удаа	Хайгуулын хугацаанд багийн ИНХ хийгээгүй. Нөлөөллийн бүсэд оршин суух малчин өрх Чулуун, Бямбаа, Мөнхболд нарынхаар орж уулзсан.
2	Өмнөговь аймгийн Байгаль Орчин, Аялал Жуулчлалын газарт	“Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу тайлан бэлтгэж хүргэх	БОХТ-ний хэрэгжилтийг байгаль орчны бүрдэл хэсэг тус бүрээр гаргасан байх	2025 онд жилд 1 удаа Метан Газ Ресурс ХХК тухайн жилийн БОХТ-ний хэрэгжилтийн тайланг боловсруулж, 3-аас доошгүй хувийг Өмнөговь аймгийн Байгаль Орчин, Аялал Жуулчлалын газарт жил бүрийн 11-р сарын 1-ний дотор хүргүүлнэ.	БОХТ-ний биелэлтийн тайланг хэвлэн Өмнөговь аймгийн Байгаль Орчины газарт хүргүүлж, цахим мэдээллийн санд оруулсан.
3	Цогтцэций сумын ЗДТГ-т	“Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу тайлан бэлтгэж хүргүүлэх	БОХТ-ний хэрэгжилтийн явцыг БО-ны бүрдэл хэсгүүдээр гарган танилцуулах	Жилд 1 удаа	Аймгаас томилогдсон ажлын хэсэгт БОМТ-ний хэрэгжилтийг хайгуулын талбай дээр танилцуулж, дүгнэлтийн хуудсаар дүгнүүлсэн бөгөөд 90.14 оноо авсан.

ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД


Хавсралт материалын жагсаалт:

- Хавсралт материал 1: Усны лабораторийн шинжилгээний үр дүнгүүдийн хуулбар
- Хавсралт материал 2: Хөрсний лабораторийн шинжилгээний үр дүнгүүдийн хуулбар
- Хавсралт материал 3: Хэрэглээний цэвэр ус тээвэрлүүлэх гэрээний хуулбар
- Хавсралт материал 4: Хатуу хог хаягдал тээвэрлүүлэх гэрээний хуулбар
- Хавсралт материал 5: Бохир ус тээвэрлэлтийн гэрээний хуулбар
- Хавсралт материал 6: Ашигласан усны хэмжээг нотлох баримт
- Хавсралт материал 7: Ус ашиглуулах дүгнэлтийн хуулбар
- Хавсралт материал 8: Ус ашиглах гэрээ
- Хавсралт материал 9: Ус ашигласны төлбөр төлсөн баримт
- Хавсралт материал 10: Хог хаягдлын хураамж төлсөн төлбөрийн баримт

Хавсралт материал 1: Хэрэглээний цэвэр усны шинжилгээний хариу

5/5/25, 12:06 PM

GASH-LIMS



Хүнсний Аюулгүй Байдлын
Үндэсний Лабораторийн
өргөсний захирлын 2023 оны 01 сарын
02-ны өдрийн А/02 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт Мөнгө 00-59

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН
СОРИЛТЫН ЛАБОРАТОРИ

Өмнөговь аймаг Даланзадгад сум, 6-р баг.
Нисэхийн 3-314 тoot
Утас: 7053-2960

ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН
CERTIFICATE OF ANALYSIS

Бүртгэлийн дугаар : 25-412
Шинжилгээ хийлгэх хүсэлт гаргасан газрын нэр : ӨМ:Цогтцэций сум Номадс катеринг
энд интегрэйтэд сервисис ХХК

Дэд лабораторийн нэр : Эрүүл ахуйн нян судлалын хяналтын
лаборатори

Дээжийн тодорхойлолт					
Дээжийн дугаар	Дээжийн нэр	Цувралын дугаар	Үйлдвэрлэсэн улс	Бүтээгдэхүүний хүчинтэй хугацаа	Дээжийн тоо хэмжээ
1820	Ундны ус /Гүний худал MGR -кемл/		Монгол Улс	Тодорхойгүй	0,5 л

Хүлээн авсан огноо	Шинжилгээ дууссан огноо	Хэвлэсэн огноо
2025 он 04 сар 30 өдөр	2025 он 05 сар 05 өдөр	2025 он 05 сар 05 өдөр

Дээжийн дугаар	Шинжилгээний аргын стандарт	Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж	Шаардлага	Шинжилгээний дүн
1820	MNS ISO 6222:1998	ББЕТ	1 мл-т 100-с ихгүй	Нянгийн тоо 23
	MNS ISO 19250:2017	Salmonella spp	25 мл-т илрэхгүй	Илрээгүй
	MNS ISO 9308-1:1998	Халуун тэсвэртэй гэдэсний бүлгийн нян /ялтас шүүлтүүр/	100 мл-т илрэхгүй	Илрээгүй

Санал тайлбар:

Санах: Энэ шинжилгээний дүн нь зөвхөн шинжилгээний үр дүнд үндэслэн хийгдсэн бөгөөд лабораторийн зөвшөөрөлгүй хуульбусаахыг хориглоно.

**БАТАЛСАН: ЛАБОРАТОРИЙН
ЭРХЛЭГЧ:**



/Г. ЧИНЗОРИГ/

Энэ шинжилгээний дүн нь зөвхөн шинжилгээний үр дүнд үндэслэн хийгдсэн бөгөөд лабораторийн зөвшөөрөлгүй хуульбусаахыг хориглоно.



**ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ГАЗАРЗҮЙ ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН
ХӨРСНИЙ ЛАБОРАТОРИ**

Хаяг: Монгол улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг,
7-р хороо, Эрхүүгийн гудамж, 11-р хороолол
Утас: +976 99141955
E-mail: soilab.IGG@gmail.com

Хөрсний задлан шинжилгээний дүн

Дээж авсан газрын нэр: Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Тавантолгой
